

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2023 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар оруулах/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
<b>Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.</b>							
<p><i>“Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</i></p>							
1.1.	Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлтэй холбоотой нийгмийн даатгалын дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн батлуулах талаар холбогдох саналыг боловсруулан шаардлагатай судалгаа, тооцооны хамт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэх;	Шаардлагагүй	Нийгмийн даатгалын шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжтой холбоотойгоор өмнө хэрэглэж байсан дүрэм, журам, заавар, аргачлалыг шинэчлэн баталсан байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/197 дугаар тушаалаар баталсан Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсгийн хүрээнд Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлснээр Улсын Их хуралд өргөн барив. Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Нийгмийн бодлогын байнгын хорооны зөвлөхүүдтэй хамтран хэлэлцэх саналын томъёолол бэлтгэх ажлыг зохион байгуулсан.	Шаардлагатай тооцоо судалгааны санал боловсруулан хүргүүлсэн байна.	1. Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийг хэлэлцэн баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөхөөр шийдвэрлэсэн. 2. ХНХЯ-аас санал авахаар ирүүлсэн УИХ-ын тогтоолоор батлах 1, Засгийн газрын тогтоолоор батлах 15, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын болон Сангийн сайд, Эрүүл мэндийн сайд, Гадаад харилцааны сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын хамтарсан тушаалаар батлах 18, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор батлах 13 дүрэм,	100

					<p>журмаас 33 дүрэм, журмын төсөлтэй танилцан, 23 дүрэм, журамд холбогдох саналыг тусган боловсруулж, төслийг албан бичгээр ХНХЯ-д хүргүүлээд байна.</p> <p>Бусад 10 дүрэм, журмын төсөлд оруулах саналыг боловсруулан ажиллаж байна.</p> <p>Санал өгсөн дүрэм журмаас Засгийн газрын тогтоолоор 2, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Эрүүл мэндийн сайд, Гадаад харилцааны сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын хамтарсан тушаалаар 7, нийтдээ 9 дүрэм, журам батлагдсан байна.</p> <p>3. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төслийг танилцуулах, шинэчлэн батлагдсан хуулиудын дагуу боловсруулах дүрэм, журам, заавар, аргачлалын төслийг Нийгмийн даатгалын хэлтсүүд, ажил олгогч, даатгуулагч, иргэдэд танилцуулах, санал авах уулзалт хэлэлцүүлгийг Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймагт зохион байгуулсан.</p>		
1.2.	Нийгмийн даатгалын тухай хууль	Шаард-лагагүй	2023 оноос хэрэгжих хууль тогтоомжтой	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой 1	Нийгмийн даатгалын	1. Нийгмийн даатгалын хуулийн болон холбогдох бусад	100

	<p>тогтоомжид орсон өөрчлөлтийн хэрэгжилтийг зохион байгуулах, холбогдох журам, заавар, зөвлөмж, чиглэлийг боловсруулан батлуулж төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагыг мэргэжил, арга зүйгээр ханган ажиллах;</p>		<p>холбоотойгоор шинэчлэн батлагдсан дүрэм, журам, заавар төв, орон нутгийн байгууллагуудад хүргэгдсэн байна.</p>	<p>журам, 4 заавар, 11 зөвлөмж чиглэлийг хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.</p>	<p>тухай хууль тогтоомжид 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэх чиглэлээр орсон өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх журам, заавар, чиглэл боловсруулан төв, орон нутгийн байгууллагуудад хүргүүлж. хяналт тавьж ажилласан байна.</p>	<p>шийдвэрүүдийн 2023 онд дагаж мөрдөх өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх 12 удаагийн зөвлөмжийг ННДГ, аймаг, дүүргийн НДХ-үүдэд хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>2. Засгийн газрын 2023 оны 60 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацааны нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”-ын хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд “Тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаа ажилтан”, “Цэрэг, цагдаагийн байгууллагын захиалгаар суралцагч цэргийн цолтой алба хаагч”, “Хууль бусаар ажлаас зайлуулагдан мөрдөгдсөн, хилс хэргээр хорих ял эдэлсэн даатгуулагч”, “Цаг уурын хүнд нөхцөл бүхий улс дахь Дипломат төлөөлөгчийн газарт ажиллагчдын ажилласан жилийг нэмэгдүүлэн тооцох хугацаа”-г ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн программд бүртгэх даатгуулагчийн төрлийн кодыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Даатгуулагчийн төрлийн код шинээр батлах тухай” А/36, “Даатгуулагчийн төрлийн код шинээр батлах тухай” А/43 дугаар тушаалуудаар батлуулан, нийгмийн даатгалын шимтгэл тооцон төлүүлэх ажлын</p>	
--	---	--	---	---	--	---	--

					<p>хэрэгжилтийг зохион байгуулав.</p> <p>3. НДЕГ-ын даргын 2023 оны “Хуваарь батлах тухай” А/113 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын батлах 11 журмыг боловсруулан батлуулах журам, зааврын хуваарийг баталж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>НДЕГ-ын даргын 2023 оны А/139 дүгээр тушаалаар “Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журам”, А/147 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан хүлээн авах, хянах, залруулга хийх, баталгаажуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан журам”-ыг баталж ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр хүргүүлээд байна.</p> <p>“Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сан тус бүрийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, хугацаа, хяналт тавих журам”, “Үйлдвэрлэлийн ослын улмаас сул зогссон хугацааг тогтоох журам”, “Татварын албатай цахимаар мэдээлэл харилцан солилцох журам”-ын төслийг нийгмийн даатгалын байгууллагын төв, орон нутгийн газар, хэлтэст хүргүүлэн,</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>танилцуулж холбогдох саналыг тусган боловсруулж, 2023 оны 12 дугаар сард батлахаар ажиллаж байна.</p> <p>4. “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэх маягтын загвар, тэдгээрийг хэвлүүлэх, үнэ тогтоох, зарцуулах, тайлагнах журам”, “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид бүртгэлийн дугаар олгох, хэрэглэх болон хувийн хэрэг нээх, бүртгэх, хөтлөх, шилжүүлэх журам”, “Илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох харилцааг зохицуулсан журам”, “Нийгмийн даатгалын шимтгэлийн ногдуулалт, төлөлтөд хяналт шалгалт хийх журам”, “Тэтгэвэр тогтоолгох өргөдлийн маягтын загвар, тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам, тэтгэвэр бодох заавар”, “Тэтгэмж тогтоолгох өргөдлийн маягтын загвар, тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг авах эрх бүхий иргэн, албан тушаалтныг тодорхойлох журам, тэтгэмж бодох аргачлал, заавар”-ын төслийг боловсруулан холбогдох олон нийтээс санал авахаар <a href="http://www.ndaatgal.mn">www.ndaatgal.mn</a> цахим хуудаст байршуулав.</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>Эдгээр 6 журмыг 2023 оны 12 дугаар сард баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулна.</p> <p>5. ЗГ-ын 2023 оны 60 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацааны нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”, 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар тогтоол, “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 239 дүгээр тогтоол, 2023 оны 362 дугаар тогтоолоор баталсан “Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрэм”, ХНХС-ын 2023 оны “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай” А/01 дүгээр тушаал, 2023 оны А/137 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох журам”, ГХС, ХНХС-ын 2023 оны “Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах жишиг цалин хөлсний хэмжээг батлах тухай” А/69, А/132 дугаар хамтарсан тушаал, НДЕГ-</p>	
--	--	--	--	--	--	--

						ын даргын 2023 оны А/59 дүгээр тушаалаар өөрчлөлт оруулсан “Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам”-ыг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд холбогдох зөвлөмжийн хамт хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	
1.3.	Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулсан үр дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэх;	Шаард- лагагүй	Нийгмийн даатгалын шимтгэл буцаан олгосон даатгуулагчийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ	2022 онд нийт 683.7 мянган даатгуулагчид 85.1 тэрбум төгрөгийн шимтгэлийг буцаан олгов.	Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулсан үр дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.	Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/99 дүгээр тушаалаар “Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад баримтлах журам”-ыг баталж аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллав. Уг хуулийг хэрэгжүүлэхэд 2022 онд давхардсан тоогоор 2.4 сая даатгуулагчид 84.4 тэрбум төгрөгийн шимтгэлийг буцаан олгосон бөгөөд тайланг НДЕГ-ын 2023 оны “Тайлан хүргүүлэх тухай” 01/666 дугаар албан бичгээр ХНХЯ-нд хүргүүлсэн.	100
1.4.	Даатгуулагч төвтэй нийгмийн даатгалын үйлчилгээний бүтээмжийг дээшлүүлэн цахимаар үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;	Шаард- лагагүй	Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг нэмэгдүүлнэ.	2023 оны эхний хагас жилийн байдлаар 8 аймгийн нийгмийн даатгалын хэлтэс нийтдээ 135.1 мянган тэтгэврийн хувийн хэргээс 75.5 мянган хувийн хэргийг цахимжуулж, цахимжилт 55.9 хувьтай байна.	Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, цахим	1. “Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд хийгдсэн программ хангамжийг турших, нэвтрүүлэх, хүлээн авахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий “Дэд ажлын хэсэг”-ийн 42 удаагийн уулзалтад оролцож, Нийгмийн	90

					<p>хэлбэрт шилжүүлсэн ажлын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.</p>	<p>даатгалын мэдээллийн шинэчилсэн цогц (Core) систем нэвтрүүлэхтэй холбоотой программ хүлээн авах “Шалгах хуудас”-ыг нийгмийн даатгалын бүтээгдэхүүн бүрт нэг бүрчлэн нарийвчлан ярилцаж, ажил олгогчийн шимтгэл төлөлтийн, Сайн дурын даатгалын, Тэтгэврийн, Тэтгэмжийн, ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн, Ажилгүйдлийн тэтгэмжийн, Өөрчлөлт, Зөрчил, Төлөвлөлт зэрэг програм хангамжид тулган шалгах ажлыг МТТ, СБГ, ДАМГ, ТГ, ХШГ, “Ай ти зон” ХХК-тай хамтран хийж гүйцэтгэв.</p> <p>2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Олон улсын хөдөлмөрийн байгууллагын санхүүжилтээр тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулж, тэтгэвэр авагчдын тэтгэврийг цахимаар шалгаж тогтоох, цахим хяналт шалгалтыг сайжруулах, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг шуурхай үзүүлэх зорилгоор Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Ховд, Хөвсгөл, Увс аймгийн нийгмийн даатгалын хэлтэс болон сумдын байцаагч нарыг олон үйлдэлт хувилах машинаар хангав.</p> <p>Энэхүү ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласнаар 2023 онд 8 аймгийн нийгмийн даатгалын хэлтэс нийтдээ 115.9 мянган тэтгэврийн хувийн хэргийн 82.6 хувь буюу 95.7 мянган</p>	
--	--	--	--	--	---	---	--



					<p>хувийн хэргийг цахимжуулав.</p> <p>3. Нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх зорилгоор Засгийн засгийн газраас авч хэрэгжүүлсэн тэтгэврийн нэмэгдлийн мэдээллийг ил тод байлгах, тэтгэвэр авагч, иргэдийг мэдээллээр хангах зорилгоор www.ndaatgal.mn сайтын даатгуулагчийн вэб дэд хэсэг, төрийн үйлчилгээний emongolia цахим системд тэтгэврийн өөрчлөлтийн тооцоог тэтгэвэр авагчид харуулах, шалгах тохиргоог оруулж хэрэгжилтийг зохион байгуулсан.</p> <p>4. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийн бэлтгэл ажлын хүрээнд тэтгэврээ 2019-2023 онд дараалсан 6 эсхүл 7 жилийн цалин хөлсний дунджаас тогтоолгосон, тэтгэврээ 5 жилийн цалин хөлснөөс өөрчлүүлэх тэтгэвэр авагчийн хүсэлтийг нийгмийн даатгалын хэлтэст биеэр ирж өгөхгүйгээр цахимаар ирүүлэх, баталгаажуулах боломжийг бүрдүүлэв.</p> <p>Энэхүү ажлын хүрээнд иргэний өөрчлөгдсөн тэтгэврийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр олгох ажлыг шуурхай зохион байгуулж байна.</p>		
1.5.	Донорын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйл, Нийгмийн даатгалын үндэсний	Шаардлагагүй	Эрүүл мэндийн сайдын тушаалаар “Даатгуулагчийг донор болж эс, эд эрхтэнээ бусдад	-	Эрүүл мэндийн сайдын тушаалаар “Даатгуулагчи	Эрүүл мэндийн сайдын 2023 оны “Журам батлах тухай” А/198 дугаар тушаалын 8 дугаар хавсралтаар “Амьгүй донор болсон тухай тодорхойлолт”-ын	100

	зөвлөлийн 2022 оны “Оршуулгын тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 4 дүгээр тогтоолд заасан /амьгүй донор болж эс, эд эрхтэнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт оршуулгын тэтгэмж олгох/ ажлыг Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулах;		шилжүүлэхээр болсон талаарх тодорхойлолт”-ыг батлуулна.		йг донор болж эс, эд эрхтэнээ бусдад шилжүүлэхээр болсон талаарх тодорхойлолт ”-ыг батлуулж, оршуулгын тэтгэмжийг олгох ажлыг зохион байгуулсан байна.	маягтын загварыг батлуулсан. Уг батлагдсан маягтаар гаргасан тодорхойлолтын дагуу нийгмийн даатгалын байгууллага 2023 онд амьгүй донор болж эс, эд, эрхтэнээ бусдад шилжүүлсэн, оршуулгын тэтгэмж олгох нөхцөлийг хангасан 1 даатгуулагчийн ар гэрт гурван сая таван зуун мянган төгрөгийн тэтгэмж олгосон.	
1.6.	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2023 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тооцож, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;	Шаард- лагагүй	2023 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан батлуулна.	Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2022 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тооцож, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 07 дугаар тогтоолоор хүүгийн хэмжээг 9.8 хувиар батлуулсан.	Нэрийн дансны хүүгийн хэмжээг тооцон, Үндэсний статистикийн хорооны саналыг авч, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр батлуулсан байна.	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2023 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр батлуулах бэлтгэл ажлын хүрээнд 2022 онд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчдын цалин хөлсний дунджийг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд үндэслэн гаргав. Нэрийн дансны 2023 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг 2019-2022 оны нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчдын дундаж цалинд үндэслэн тооцож, Үндэсний статистикийн хорооны саналыг авахаар албан бичгээр хүргүүлэв. ҮСХ-ноос ирүүлсэн саналыг НДҮЗ-д уламжлан батлуулахаар хүлээгдэж байгаа бөгөөд тайлант ондоо багтаан батална.	90
1.7.	Нэрийн дансны 2022 оны орлогод хүү	Шаард- лагагүй	2021 оны нэрийн дансны үлдэгдлийн	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд	Тэтгэврийн даатгалын	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2022	100

	тооцон эцсийн үлдэгдлийг өөрчлөн даатгуулагчдад мэдээлэл хүргэх;		хэмжээг 9.8%-иар тооцож бүртгэнэ.	2022 оны жилийн эцсийн байдлаар 1.5 сая даатгуулагчийн 27.4 их наяд төгрөгийн шимтгэл болон шимтгэлд тооцсон хүүг бүртгэв.	шимтгэлийн нэрийн дансны 2022 оны эцсийн үлдэгдлийг тооцон даатгуулагчид мэдээлсэн байна.	оны орлогод 1,588.3 мянган даатгуулагчийн 27.4 их наяд төгрөгийн шимтгэл болон шимтгэлд тооцсон хүүг бүртгэв. Даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээлэх хуудсаа "Нийгмийн даатгал" аппликэйшн, www.ndaatgal.mn цахим хуудсанд дахь "Даатгуулагчид зориулсан вэб", төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох "ХУР" систем, төрийн үйлчилгээний нэгдсэн портал "E-Mongolia" системээс цахимаар авах боломжийг бүрдүүлсэн.	
1.8.	Малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч иргэдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах ажлыг зохион байгуулах, үр дүнг тооцож ажиллах;	Шаардлагагүй	Нийгмийн даатгалд шинээр хамруулах сайн дурын даатгуулагч (малчин)-ийн тоог нэмэгдүүлнэ.	Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нартай байгуулсан 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шинээр даатгалд хамруулах даатгуулагчийн төлөвлөгөөг 11,5 мянган даатгуулагчаар тусган эхний хагас жилийн байдлаар 21,3 мянган иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулав. Үүнээс 7 мянган малчинтай сайн дурын даатгалын гэрээг цахимаар байгуулах ажлыг зохион байгуулав.	Сайн дурын даатгуулагч (малчин)-ийн тоог өмнөх оноос нэмэгдүүлсэн байна.	Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор 23.1 мянган даатгуулагчийг шинээр сайн дурын даатгалд хамруулах төлөвлөгөөг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгав. 2023 оны жилийн эцсийн байдлаар 28.1 мянган иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулсан байна. Үүнээс 9.0 мянган малчинтай сайн дурын даатгалын гэрээг цахимаар байгуулах ажлыг зохион байгуулав.	100
1.9.	Нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчдыг шинээр	Шаардлагагүй	Шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоог нэмэгдүүлнэ.	2022 онд 4.4 мянган аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр бүртгэж, 134.1 мянган иргэнийг албан журмын даатгалд хамруулсан.	ААНБ, даатгуулагчдын тоог өмнөх оноос нэмэгдүүлсэн байна.	Албан журмын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор 4.9 мянган ажил олгогч, 26.9 мянган даатгуулагчийг шинээр хамруулах төлөвлөгөөг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын	90

	хамруулах ажлыг зохион байгуулах;					хэлтсийн дарга нарын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгав. Энэхүү ажлын үр дүнд 2023 оны жилийн эцсийн байдлаар 5.4 мянган аж ахуйн нэгж, байгууллага, 22.7 мянган даатгуулагчийг албан журмын даатгалд шинээр хамруулав.	
1.10.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, үр дүнг сурталчлан ажиллах;	1.57 тэрбум төгрөг	Төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хийж гүйцэтгэн, хууль тогтоомжийн дагуу хөрөнгийг зарцуулна.	2023 оны төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээний төсөв 1548.9 сая төгрөгөөр батлагдсанаас, 5 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 27 арга хэмжээг зохион байгуулж 539.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж, бүлэгт хүрсэн байна.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны баталсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөө"-нд нийт 64 арга хэмжээ зохион байгуулж, уг арга хэмжээнд 1,548.9 сая төгрөгийн төсөв зарцуулахаар тусгагдсанаас, жилийн эцсийн байдлаар 56 арга хэмжээг зохион байгуулж, 1,376.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгов.	90
1.11.	Өндөр насны тэтгэвэр тогтоохтой холбоотой 2023 онд мөрдөх хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, иргэдэд хуулийг сурталчлан таниулах, төв, орон нутгийн албадыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах;	Шаардлагагүй	Чиглэл, зөвлөмж хүргүүлнэ.	2022 онд 373.2 мянган тэтгэвэр авагчийн өндөр насны тэтгэвэрт 2,406.5 сая төгрөгийг зарцуулсан. Төв, орон нутгийн албадад 2 удаагийн чиглэл, зөвлөмжийг хүргүүлсэн.	Хуулийг хэрэгжүүлэх талаар чиглэл, зөвлөмж өгч, мэргэжил, арга зүйгээр хангаж ажилласан байна.	1. Төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагуудад 2023 онд өндөр насны тэтгэвэр тогтоох нас болон шимтгэл төлсөн байвал зохих хугацаа, "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлийн ажил мэргэжлийн жагсаалт"-д орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэх, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчийн тэтгэвэр авагчид өндөр насны тэтгэвэр тогтоож, олгохтой	100

					<p>холбоотой асуудлаар 6 удаагийн зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>2. Засгийн газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар, “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 239 тогтоолуудын хэрэгжилтийг зохион байгуулан нийгмийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тогтоосон цэргийн алба хаасны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны нийтдээ 488.8 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг шинэчлэн тогтоож, нэмэгдүүлэн олгов.</p> <p>Дээрх тогтоолуудын дагуу 326.8 мянган хүний тэтгэвэр тогтоолгосон цалинг шинэ итгэлцүүрээр өсгөж шинэчлэн тогтоож, уг тэтгэврийн хэмжээг нь 10 хувиар нэмэгдүүлэн олгов.</p> <p>Дундаж тэтгэврийн хэмжээ 2023 оны 06 дугаар сард 560.4 мянган төгрөг байсан бол шинээр баталсан итгэлцүүрээр тэтгэврийг шинэчлэн бодоход дундаж тэтгэвэр сард 622.3 мянган төгрөг, уг тэтгэврийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлэхэд дундаж тэтгэвэр сард 687.7 мянган төгрөг болж нэмэгдэв.</p> <p>Мөн Засгийн газраас бүрэн тэтгэврийн доод хэмжээг 550.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 440.0</p>	
--	--	--	--	--	---	--

						мянган төгрөг болгон нэмэгдүүлсэн шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	
1.12.	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоох, олгох ажлыг зохион байгуулан, хууль тогтоомжид орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэх чиглэлээр төв, орон нутгийн албадыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах;	Шаардлагагүй	Чиглэл, зөвлөмж хүргүүлнэ.	2022 онд 20.8 мянган цэргийн тэтгэвэрт 201.9 тэрбум төгрөгийг зарцуулсан. Төв, орон нутгийн албадад 2 удаагийн чиглэл, зөвлөмжийг хүргүүлсэн.	Хуулийг хэрэгжүүлэх талаар чиглэл, зөвлөмж өгч, мэргэжил, арга зүйгээр хангаж ажилласан байна.	<p>1. ОБЕГ, ЦЕГ, ШШЕГ, ШШГЕГ-ын зөвлөмжийн хүрээнд Гамшгаас хамгаалах тухай, Цагдаагийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай, Шүүхийн шинжилгээний тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудыг хэрэгжүүлэх 4 удаагийн чиглэл, зөвлөмжийг ННДГ, аймаг, дүүргийн НДХ-үүдэд хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>2. Монгол Улсын Хилийн тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хил хамгаалах байгууллагын алба хаагч, улсын хил дээр алба хааж байгаа офицер, ахлагч нарын ажил эрхлээгүй гэр бүл, Хилийн цэргийн сургуульд сонсогчоор суралцсан болон хугацаат цэргийн алба хаасан иргэдийн хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг баталгаажуулах, нийгмийн баталгааг хангах зорилгоор ХХЕГ, НДЕГ-ын хамтран ажиллах санамж бичгийг байгуулах ажлыг зохион байгуулав.</p> <p>3. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 1995-1996 онд хугацаат цэргийн</p>	100

						албыг байлдагч, түрүүчээр хаасан алба хаагчдын хугацаандаа төлөгдөөгүй нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх чиглэлээр ЗХЖШ-тай хамран 12 нийгмийн даатгалын хэлтэс, 34 зэвсэгт хүчний анги, нэгтгэлийг хамруулсан ажлын хэсгийг байгуулах, ажлын төлөвлөгөө боловсруулах, мэргэжил арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулж байна.	
<b>Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт</b>							
<b>“Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b>							
2.1.	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх ажил зохион байгуулах;	-	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны “2023 оны төсвийн хуваарь батлах тухай” 06 дугаар тогтоолын дагуу орлогын гүйцэтгэлийг хангуулна.	Нийгмийн даатгалын санд 3,445.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн.	Нийгмийн даатгалын санд 3,739.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.	Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулиар жилийн эцсээр 4,175.2 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулахаас 4,206.3 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулж, төлөвлөгөөг 100.7 хувиар биелүүлэв. Үүнд: - Тэтгэврийн даатгалын санд 3,566.2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 3,608.4 тэрбум төгрөг; - Тэтгэмжийн даатгалын санд 296.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 289.8 тэрбум төгрөг; - ҮОМШӨ-ний даатгалын санд 249.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 250.8 тэрбум төгрөг; - Ажилгүйдлийн даатгалын санд 62.6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 57.3 тэрбум	100

						<p>төгрөгийн орлого тус тус төвлөрүүлээ.</p> <p>Үүнээс Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулиар батлагдсаны дагуу улсын төсвөөс нийт 764.4 тэрбум төгрөгийн төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас авав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тэтгэврийн даатгалын санд 757.9 тэрбум төгрөг;</li> <li>- Тэтгэмжийн даатгалын санд 0.9 тэрбум төгрөг;</li> <li>- ҮОМШӨ-ийн даатгалын санд 5.4 тэрбум төгрөг;</li> <li>- Ажилгүйдлийн даатгалын санд 0.2 тэрбум төгрөгийг тус тус нэхэмжилж авав.</li> </ul>	
2.2.	<p>Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хүрээнд даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хуульд заасан хугацаанд олгох, урсгал үйл ажиллагааны зардлыг ангиллын дагуу зарцуулах;</p>	-	<p>Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны “2023 оны төсвийн хуваарь батлах тухай” 06 дугаар тогтоолын дагуу зарлагын гүйцэтгэлийг хангуулна.</p>	<p>Нийгмийн даатгалын сангаас 3,376.4 тэрбум төгрөг олгосон.</p>	<p>Нийгмийн даатгалын сангаас 3,748.0 тэрбум төгрөг олгосон байна.</p>	<p>Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулиар 4,152.7 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохоор батлагдсанаас 3,997.8 тэрбум төгрөг олгож, 96.3 хувийн гүйцэтгэлтэй гарав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тэтгэврийн даатгалын сангаас 3,776.0 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 3,629.4 тэрбум төгрөг;</li> <li>- Тэтгэмжийн даатгалын сангаас 236.2 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 217.3 тэрбум төгрөг;</li> <li>- ҮОМШӨ-ний даатгалын сангаас 59.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 38.8 тэрбум төгрөг;</li> <li>- Ажилгүйдлийн даатгалын сангаас 81.4 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 112.3 тэрбум төгрөг тус тус</li> </ul>	100



						зарцууллаа.	
2.3.	Нийгмийн даатгалын байгууллагуудад сангийн болон үйл ажиллагааны урсгал санхүүжилтийг шилжүүлэх;	-	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны “2023 оны төсвийн хуваарь батлах тухай” 06 дугаар тогтоолын дагуу санхүүжилт олгоно.	Нийгмийн даатгалын байгууллагуудад 1,107.7 тэрбум төгрөгийн сан болон урсгал зардлын санхүүжилт олгосон.	Нийгмийн даатгалын байгууллагуудад 1,104.3 тэрбум төгрөгийн сан болон үйл ажиллагааны урсгал зардлын санхүүжилт олгосон байна.	Сангийн харилцах дансанд даатгуулагчдад олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн санхүүжилтэд 1,132.9 тэрбум төгрөг шилжүүлсэн байна. Үүнд: - Тэтгэврийн даатгалын сангаас 1,034.6 тэрбум төгрөг; - Тэтгэмжийн даатгалын сангаас 10.6 тэрбум төгрөг; - ҮОМШӨ-ний даатгалын сангаас 3.2 тэрбум төгрөг; - Ажилгүйдлийн даатгалын сангаас 37.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна. Төв, орон нутгийн байгууллагуудад батлагдсан төсвийн хуваарийн дагуу 46.9 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны урсгал санхүүжилт олгосон.	100
2.4.	Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн дагуу шимтгэлийн орлогыг цуглуулах, төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах;	-	Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар хооронд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний заалтыг хэрэгжүүлнэ.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт 510.8 тэрбум төгрөг шилжүүлсэн.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын эрүүл мэндийн даатгалын харилцах дансанд Даваа гариг бүр төвлөрсөн орлогыг шилжүүлсэн байна.	Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудаас төвлөрүүлсэн ажил олгогч, даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу Даваа гариг бүр эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах дансанд шилжүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт 652.1 тэрбум төгрөг шилжүүлсэн байна.	100
2.5.	Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний үлдэгдлээс 60 хүртэл	-	Ажил олгогчоос авах нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг оны эхний	Ажил олгогчоос авах нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 2022 оны эхний үлдэгдлээс 29.1 хувиар нэмэгдсэн.	Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн	Ковид-19 цар тахлын улмаас аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа доголдсонтой холбоотойгоор нийгмийн	70

	хувиар бууруулах;		үлдэгдлээс 60 хүртэл хувиар бууруулна.		авлагыг оны эхний үлдэгдлээс 60 хүртэл хувиар бууруулсан байна.	<p>даатгалын шимтгэлийн авлага оны эхний 354.0 тэрбум төгрөгийн авлагаас эхнээс 24.5 хувиар нэмэгдсэн.</p> <p>1. Шимтгэлийн авлагыг бууруулахаар доорх холбогдох шийдвэрүүдийг гарган, Нийгмийн даатгалын хэлтэст үүрэг, чиглэл өгч, үр дүнг тооцон ажиллав.</p> <p>- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө биелүүлэх, шимтгэлийн авлага барагдуулах тухай” А/16 дугаар тушаал батлагдан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.</p> <p>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай 2023 оны 01 дүгээр сард “Хамтран ажиллах гэрээ” байгуулан шүүхийн шийдвэртэй шимтгэлийн авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх ажлыг хамтран зохион байгуулж, талууд сар бүр шийдвэр гүйцэтгэлийн тайлан мэдээг солилцсон, үр дүнг тооцож байна.</p> <p>- ЦЕГ-т сураггүй, хаяг тодорхойгүй байгаа байгууллагыг эрэн сурвалжлах ажиллагааг эрчимжүүлэх талаар хамтран ажиллах хүсэлт хүргүүлснээр цагдаагийн байгууллагаас харъяа байгууллагууддаа чиглэл, заавар өгч, хамтран ажиллаж байна.</p> <p>- Зөвшөөрлийн тухай хуулийг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагын тусгай</p>
--	-------------------	--	--	--	---	---

					<p>зөвшөөрлийг олгох, хугацааг сунгах зэрэг асуудлыг шийдвэрлэхдээ нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй эсэхийг харгалзан үздэг байх талаар хамтран ажиллах хүсэлтийг Гадаадын иргэн, харьяатын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Барилга, хот байгуулалтын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Барилга хот байгуулалтын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, Эрчим хүчний яам, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам зэрэг байгууллагуудад хүргүүлээ.</p> <p>- ЭМДЕГ-тай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-д тус газартай гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагуудын шимтгэлийн авлагыг барагдуулах талаар хамтран ажиллах заалт оруулан сар бүр холбогдох мэдээллийг хүргүүлэн, үр дүнг тооцон ажиллаж байна.</p> <p>2. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн төлөөллийн байгууллагуудад ажилчдын нийгмийн баталгааг хангах талаар тодорхой ажлуудыг хамтран зохион байгуулах саналыг Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо,</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг газарт хүргүүлж, шийдвэрлэн ажиллаж байна.</p> <p>3. Даатгуулагчдын нийгмийн баталгааг хангах, ажил олгогчийг санхүүгийн эрсдэлээс сэргийлэх талаар хамтран ажиллах хүсэлтийг Монголын барилгын үндэсний ассоциац, Ашигт малтмал, газрын тосны газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Сангийн яамны Санхүү төрийн сангийн газар, Сангийн яамны Төсвийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж, холбогдох ажлуудыг зохион байгуулж байна.</p> <p>4. Гэрээ, тушаал, журам, хамтын ажиллагааны хүрээнд нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй аж ахуйн нэгж, байгууллагын мэдээ, судалгааг доорх газруудад хүргүүлэн, хамтран ажиллалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>- Сангийн яамны Төрийн сангийн газарт 19.0 тэрбум төгрөгийн өр үүсгэсэн 818 төсөвт байгууллагын жагсаалт;</li><li>- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт 11.9 тэрбум төгрөгийн өр үүсгэсэн 398 эрүүл мэндийн байгууллагын жагсаалт;</li><li>- Монголбанкны зээлийн мэдээллийн санд 38,008 ажил олгогчийн мэдээлэл;</li><li>- Улсын Бүртгэлийн ерөнхий газарт 495 аж ахуйн нэгж, байгууллагын судалгаа;</li></ul>	
--	--	--	--	--	---	--

					<p>- Жижиг, дунд үйлдвэрийн газарт 655 аж ахуйн нэгж, байгууллагын судалгаа.</p> <p>5. ЭМНДЕГ-ын даргын 2017 оны баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг үүссэн хугацаагаар нь ангилах, хянан шийдвэрлэх журам”-ыг хэрэгжүүлж, дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 155.6 тэрбум төгрөгийн шимтгэлийн авлага үүсгэсэн 4,118 ажил олгогчид албан шаардлага хүргүүлж, 48.2 тэрбум төгрөгийн авлага төлөгдсөн;</li> <li>- Харилцах дансны зарлагын гүйлгээг түр хугацаагаар зогсоосон 10,160 ажил олгогчийн 431.8 тэрбум төгрөгөөс 56.2 тэрбум төгрөгийн авлага төлөгдсөн;</li> <li>- Төлбөр барагдуулах хуваарь гаргаж, гэрээ байгуулсан 3,384 ажил олгогчийн 270.2 тэрбум төгрөгийн авлагаас 35.8 тэрбум төгрөгийн авлага төлөгдсөн;</li> <li>- Шүүхэд шилжүүлсэн 1,354 ажил олгогчийн 48.3 тэрбум төгрөгийн авлагаас 3.5 тэрбум төгрөгийн авлага төлөгдсөн;</li> <li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлсэн 333 ажил олгогчийн 18.4 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагаас 2.6 тэрбум төгрөгийн авлага төлөгдсөн;</li> </ul> <p><i>Тайлбар: Авлага барагдуулах арга хэмжээ нь дээрх журмын дагуу шат дараалан авч байгаа</i></p>	
--	--	--	--	--	---	--

						<p>тул авлагын мөнгөн дүн, ажил олгогчийн тоо нь давхардсан дүнгээр илэрхийлэгдсэн болно.</p> <p>Авч хэрэгжүүлсэн дээрх ажлын үр дүнд 2023 оны эхний 354.0 тэрбум төгрөгийн шимтгэлийн авлагаас 143.7 тэрбум төгрөгийн авлага барагдуулсан боловч урсгал авлага нэмэгдэж, 2023 оны 10 дугаар сарын авлага 440.7 тэрбум төгрөг байна.</p> <p>2023 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 398.0 тэрбум төгрөг байна гэж тооцож байна.</p> <p>Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын орлогод эзлэх хувь нь хүлээгдэж буй гүйцэтгэлээр 11.7 байна.</p>	
2.6.	Нийгмийн даатгалын сангийн болон урсгал зардлын гүйцэтгэлийн дүнг мэдээлэх ажлыг зохион байгуулах;	-	Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр хугацаанд нь гарган холбогдох байгууллагад хүргүүлнэ.	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хугацаанд нь гарган тухай бүр Сангийн яаманд хүргүүлсэн.	Төсвийн гүйцэтгэлийн 12 удаагийн мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	<p>Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын болон нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэл, өр авлагын мэдээг сар бүр нэгтгэн баталгаажуулж Сангийн яамны Төрийн сангийн газрын Зарлагын хэлтэс, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам, Үндэсний Статистикийн Хороо, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Монголбанк, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд тус тус хуулийн хугацаанд нь цахимаар болон албан бичгээр хүргүүллээ.</p> <p>Нийгмийн даатгалын сангийн зарлагыг эдийн засгийн ангиллаар Сангийн Яамны "Fiscal" програмд, сар бүр хуулийн хугацаанд</p>	90

						shilendans.gov.mn, ndaatgal.mn цахим хуудсанд тус тус байршууллаа.	
2.7.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах ажлыг зохион байгуулах;	-	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг 2 удаа нэгтгэн хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг 2 удаа нэгтгэн хугацаанд нь Сангийн яам, Үндэсний аудитын газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд тус тус хүргүүлсэн.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг 2 удаа нэгтгэн хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд: - Төв орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудын 2022 оны жилийн эцэс, 2023 оны эхний хагас жилийн байгууллагын болон сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлангуудыг шалган нэгтгэж, Үндэсний аудитын газар, Сангийн яам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албанд хугацаанд нь хүргүүлсэн. - Байгууллагын болон сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг хүлээн авч шалган мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласан. - Үндэсний аудитын газраас Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна	100

						<p>гэж дүгнэсэн байна.</p> <ul style="list-style-type: none"><li>- Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн аудит хийж байгаа аудиторруудтай хамтран ажилласнаар Төрийн аудитын тухай хуулийн дагуу харьяа нийгмийн даатгалын 31 байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэгдсэн.</li><li>- Үндэсний аудитын газар, Сангийн яамнаас НДЕГ-ын 2022 оны үйл ажиллагаанд хийсэн аудит болон Засгийн газрын тайлангийн аудитын хугацаанд шаардлагатай тайлбар, тоон мэдээ, мэдээллийг цаг тухай бүр гарган өгч хамтран ажилласан.</li><li>- Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Аудитын зөвлөмж хэрэгжүүлэх тухай” А/86 дугаар тушаал гарч, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, 2022 оны Аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг гарган Үндэсний аудитын газар хуулийн хугацаанд хүргүүлсэн.</li><li>- Нийгмийн даатгалын сангийн 2022 он, 2023 оны хагас жилийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн танилцуулгыг бэлтгэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албанд хуулийн хугацаанд</li></ul>	
--	--	--	--	--	--	--	--



						<p>хүргүүлж, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн, нийтэд мэдээллээ.</p> <p>- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, 2022 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, 2023 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, Аудитын зөвлөмжийн биелэлтийг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> сайтад хуулийн хугацаанд байршуулав.</p>	
2.8.	Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад байршуулж, нэмэгдүүлэх ажил зохион байгуулах;	-	Сангийн яам, ХНХЯ, НДҮЗ, Монголбанкны хамтарсан шийдвэрийг хэрэгжүүлж, сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкуудад хугацаатай байршуулна.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албанд шийдвэрийн төсөл, тооцооллыг 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдөр болон 11 дүгээр сарын 08-ны өдөр албан бичгээр тус тус хүргүүлсэн. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь энэхүү саналаа Сангийн яам болон Монгол банк руу явуулсан боловч Сангийн яамнаас татгалзсан хариу ирүүлсэн тул энэ онд арилцааны банкинд хугацаатай хадгаламж хэлбэрээр байрлуулах хөрөнгийн хэмжээ батлагдаагүй.	Банкуудад хугацаатай хадгаламж хэлбэрээр байршуулах мөнгөн хөрөнгийн дүнг тооцон, хамтарсан шийдвэрийн төслийн хамт Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд хүргүүлэх, хамтарсан шийдвэрийг хэрэгжүүлж сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкуудад	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 8 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг банкинд хадгаламж хэлбэрээр байршуулах журам”-д заасны дагуу тухайн жилд хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн хэмжээг санхүүгийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанк, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хамтарсан шийдвэрээр тогтоодог.	90
						НДҮЗ-ийн ажлын албанд дээрх шийдвэрийг гаргуулахаар хамтарсан шийдвэрийн төсөл, танилцуулга, холбгдох тооцооллыг 2023 оны 3, 9 дүгээр саруудад 01/349, 01/1469 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.	Нийгмийн даатгалын

					хугацаатай байршуулсан байна.	үндэсний зөвлөлөөс талуудад хүсэлтийг явуулсан боловч Сангийн яам зөвшөөрөөгүй, арилжааны банкинд байршуулах мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтоосон шийдвэр гараагүй тул арилжааны банкинд сангийн мөнгөн хөрөнгийг хугацаатай хадгаламж хэлбэрээр байршуулаагүй болно. Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын бонд худалдан авахад зарцуулах хөрөнгийн доод хэмжээг 300.0 тэрбум төгрөг байхаар тогтоосон. Хуулийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс 480.0 тэрбум төгрөгөөр Засгийн газрын бонд худалдан авахаар Сангийн яамтай хэлцэл хийгдэж байна.	
2.9.	Нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, удирдлагаар хангах;	-	Өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах ажлыг зохион байгуулж, “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн шийдвэрийг тухай бүр гаргана.	1. Хөрөнгийн тооллого 2 удаа зохион байгуулсан. 2. Өмч хамгаалах байнгын зөвлөл 3 удаа хуралдаж, холбогдох шийдвэрүүдийг гарган хяналт тавьж ажилласан. 3. Түрээсийн болон төрийн өмчийн эзэмшүүлэх гэрээний хэрэгжилтийг хангасан.	Өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах ажлыг зохион байгуулсан байна.	Нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин, удирдлагаар ханган ажиллаж байна. 1.“Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн 2023 оны ажлын төлөвлөгөөг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн даргаар батлуулж, төлөвлөгөөнд 9 ажил үйлчилгээг тусгасан. Хэрэгжилт 88.8 хувьтай байна. Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр үндсэн хөрөнгө актлах, үнэ шинэчлэн тогтоох,	88

					<p>балансаас балансад шилжүүлэх асуудлыг хэлэлцүүлэн ТӨБЗГ-т шийдвэр гаргуулахаар хүргүүлэхээр бэлтгэж байна.</p> <p>2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 01 дүгээр тогтоолыг үндэслэн төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудаас данснаас хасахаар ирүүлсэн анхан шатны 58,506 тоо ширхэг бүхий 25.6 сая төгрөгийн маягт, 212 тоо ширхэг бүхий 9.2 сая төгрөгийн үнэ бүхий аж ахуйн материал, 97 тоо ширхэг бүхий 3.6 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэлийг данснаас хасах Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/89 дүгээр тушаалаар баталлаа.</p> <p>3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны “Төрийн өөрийн өмчийн түрээсийн талаарх зарим арга хэмжээний тухай” 50 дугаар тогтоолоор баталсан Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загварын дагуу төв, орон нутгийн Нийгмийн даатгалын 11 байгууллага нийт 70.4 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлэх гэрээ байгууллаа.</p> <p>4. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/92 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалын байгууллагын эд хөрөнгийн тооллого явуулах журам”-ыг шинэчилсэн.</p> <p>5. Нийгмийн даатгалын багц</p>	
--	--	--	--	--	---	--

						<p>хууль хэрэгжихтэй холбогдуулан "Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэх маягтын загвар, тэдгээрийг хэвлүүлэх, үнэ тогтоох, зарцуулах тайлагнах журам"-ыг шинэчлэн боловсруулав.</p> <p>6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагын автомашин ашиглах журам"-ыг хүчингүй болгосон.</p> <p>7. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны А/82 тушаалаар 2019 оны "Зарим нормативыг шинэчлэн тогтоох тухай" 117 дугаар тушаалын 2, 4 дүгээр хавсралтыг хүчингүй болгосон.</p>	
2.10.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын эзэмшилд байгаа үл хөдлөх хөрөнгийн нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулах;	-	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 18,19 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 268, 269 дүгээр тогтоол, дуудлага худалдааны журам болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу Нийгмийн даатгалын сангийн авлагд шилжүүлэн авсан хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар	<p>1. Үл хөдлөх хөрөнгийн нээлттэй дуудлага худалдааг нийт 8 удаа зохион байгуулж, 5.9 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 19 хөрөнгийг 6.0 тэрбум төгрөгөөр зарж, орлогыг нийгмийн даатгалын санл төвлөрүүлэн ажилласан.</p> <p>2. Нийт 26 иргэн, 8 байгууллагаас 198.5 сая төгрөгийн түрээсийн орлогыг нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн.</p>	Холбогдох журмын дагуу нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах, түрээслэх ажлыг зохион байгуулж, орлогыг санд төвлөрүүлсэн байна.	Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн нийгмийн даатгалын сангийн өр, төлбөрт тооцон авсан хөрөнгийг худалдан борлуулах нээлттэй дуудлага худалдааг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны "Журам батлах тухай" 18 дугаар тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын сангийн авлагд үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга	90

		<p>худалдан борлуулах, түрээслүүлэх ажлыг зохион байгуулна.</p>			<p>хэмжээний тухай” 268 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын 2022 оны 7-1/2608 дугаар албан бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/29, 2023 оны А/186 дугаар тушаалаар 2 удаагийн дуудлага худалдааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж, 304.9 сая төгрөгийн үнэлгээтэй хөрөнгийг 313.9 сая төгрөгөөр борлуулав.</p> <p>- “Үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-ээр 3 орон сууцыг 393.9 сая төгрөгөөр борлуулсан.</p> <p>- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанаар Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн төлбөрт хүлээн авсан хөрөнгүүдийн тухай асуудлыг хэлэлцүүлснээр “Хөрөнгө гэрээгээр худалдах зөвшөөрөл олгох тухай” 02 дугаар тогтоол батлагдаж, Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчаас нийгмийн даатгалын сангийн нэхэмжилсэн өр төлбөрт тооцон авсан, гурав ба түүнээс дээш нээлттэй дуудлага худалдаагаар борлуулагдаагүй хөрөнгүүдийг иргэн, хуулийн этгээд, үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагуудтай “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулан, төлбөрийг 36 сараас ихгүй хугацаанд төлж барагдуулах шийдвэр гарсан.</p>	
--	--	---	--	--	--	--

						<ul style="list-style-type: none"> <li>- Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компаниудтай хамтран ажиллах урилгын зарыг өдөр тутмын сонин болон цахим хэлбэрээр олон нийтэд хүргэснээр одоогийн байдлаар хүсэлт ирүүлсэн 8 байгууллагатай “Үл хөдлөх эд хөрөнгийг худалдахад зуучлах гэрээ” байгуулан хөрөнгийн худалдан борлуулах ажлыг зохион байгуулж байна.</li> <li>- Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагаар дамжуулан 0.6 тэрбум төгрөгийн өртөгтэй 3 ширхэг орон сууцыг борлуулж, нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн.</li> <li>- Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байсан 34 аж ахуй нэгж, иргэнтэй түрээсийн гэрээг байгуулан 140.5 сая төгрөгийн түрээсийн орлогыг Нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн.</li> </ul>	
2.11.	“Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн Green Finance, “Бараа материал” систем хөгжүүлэлтийн ажлыг дуусгавар болгох, хүлээн авахтай холбоотой ажлуудыг гүйцэтгэх;		Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, хуульд нийцүүлэн хүлээн авна.	Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн Green Finance, “Бараа материал” системийг төсөл хэрэгжүүлэгч Ай Ти Зон ХХК-тай салбарын хэмжээнд туршиж, нэвтрүүлсэн.	Нийгмийн даатгалын байгууллагын Green Finance, “Бараа материал” системийн хөгжүүлэлтүү д дуусгавар болж, систем хүлээн авах хуудсаар Ай Ти Зон ХХК-	Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгч байгууллага (Ай Ти Зон ХХК)-д Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайланг Засгийн газрын Э тайлангийн системд илгээх, хоорондын тооцоо хийх, Сангийн сайдын 100, 347, 388 дугаар тушаалын дагуу анхан шатны маягтуудыг системээс загварын дагуу гаргах, аудитын маягт, төсвийн системээс төсвийг татах, үндсэн	100

					тай хүлээлцсэн байна.	<p>хөрөнгийн тооллогын ТӨ, ТӨХ маягтуудыг системээс гаргах талаар саналуудыг хүргүүлэн хөгжүүлэлтийг хийлгэж ажиллав.</p> <p>БНСУ-ын Нийгмийн даатгалын тасаг дээр 2022 оны онд аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу гадаад валютын ханшийн зөрүүг систем дээр зөв бүртгэх боломжийг бүрдүүлж хөгжүүлэлтийн ажлыг хийсэн.</p> <p>Байгууллагын санхүү системийг модуль тус бүрээр шалган, систем хүлээлцэх тойрох хуудсаар хүлээлцлээ.</p> <p>Төсвийн системийн 5, хүний нөөцийн системийн 11, сангийн санхүүгийн системийн 6, татварын системтэй холбоотой 5, аудитын болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын системтэй холбоотой 2, Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн Э-тайлангийн системтэй холбоотой 1 ажлуудыг хөгжүүлэлт дутуу бөгөөд саппорт гэрээнд тусгахаар тохиролцов.</p> <p>Бараа материалын системийг хүлээлгэн өгөх хуудсыг нэг бүрчлэн үзэж хүлээлцэх ажлыг хийж байна.</p> <p>Тус системээр Нийгмийн даатгалын байгууллагын 2022 оны болон 2023 оны 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн тайланг гарган, холбогдох хөгжүүлэлтийг тухай бүр хийсэн.</p>	
2.12.	Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын	Нийгмийн даатгалын	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр батлуулан, хуваарийн дагуу	Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан нийгмийн	Төсвийн аймаг, нийслэл, дүүргийн	НДЕГ-ын даргын 2023 оны А/04 дүгээр тушаалаар нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны урсгал зардлын	100

	<p>үндэсний зөвлөлийн баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын нийгмийн даатгалын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн аймаг, нийслэл, дүүргийн нарийвчилсан хуваарь, Газрын даргын баталсан сар, улирлын хуваарийг төв, орон нутгийн нийгмийн даатгалын албадад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;</p>	<p>сангийн орлого 3,739.3 тэрбум төгрөг (Улсын төсвийн татаас орсон дүн), зарлага 3,748.0 тэрбум төгрөг, үйл ажиллагааны урсгал зардал 37.0 тэрбум төгрөг</p>	<p>төсвийг байна. олгосон</p>	<p>даатгалын сангийн орлого, зарлагын болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн аймаг, нийслэл, дүүргийн нарийвчилсан хуваарь, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан сар, улирлын хуваарийг төв, орон нутгийн албадад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.</p>	<p>нарийвчилсан хуваарь, Газрын даргын баталсан сар, улирлын хуваарийг нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэн уг хуваарийн дагуу тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, нийгмийн даатгалын байгууллагын урсгал зардлын төсвийг олгосон байна.</p>	<p>төсвийн 2023 оны сар, улирлын хуваарийг батлуулан, хэрэгжүүлэх зөвлөмжийн хамт НДЕГ-ын даргын 2023 оны “Зөвлөмж хүргүүлэх тухай” 01/109 дүгээр албан бичгээр аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс /газар/-үүдэд хүргүүлсэн.</p> <p>Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2023 оны төсвийн хуваарьт өөрчлөлт орсонтой холбоотойгоор НДЕГ-ын даргын 2023 оны А/49 дүгээр тушаалаар батлуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.</p> <p>Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар нийгмийн даатгалын сангийн орлогыг 4,175.2 тэрбум, үүнээс төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаасыг 774.4 тэрбум, сангийн зарлагыг 4,152.7 тэрбум төгрөгөөр тус тус өөрчлөн баталсан.</p> <p>Энэ хуулийн дагуу НДҮЗ-ийн 2023 оны 05 тоот тогтоолоор Нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны урсгал зардлын тодотгосон төсвийн аймаг, нийслэл, дүүргийн нарийвчилсан хуваарийг НДЕГ-ын даргын 2023 оны А/105 дугаар тушаалаар сар, улирлын хуваарийг батлуулан, хэрэгжүүлэх зөвлөмжийн хамт НДЕГ-ын 2023 оны “2023 оны</p>	
--	---	---	-------------------------------	--	--	---	--



						<p>тодотгосон төсвийн хуваарь хүргүүлэх тухай” 01/1432 дугаар албан бичгээр аймаг, нийслэл дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс /газар/-үүдэд хүргүүлэв.</p> <p>НДЕГ-ын даргын 2023 оны А/135 дугаар тушаалаар 2023 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан батлуулж, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.</p>	
2.13.	<p>Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсөөллийн саналыг төв, орон нутгийн нийгмийн даатгалын албадаас хүлээн авч хянан боловсруулж, саналыг хүргүүлэх;</p>	Шаард лагагүй	<p>Төсвийн тухай хуулийн 8.4 дэх хэсэгт заасны дагуу 08.01-ний өдрийн дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлнэ.</p>	<p>2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсөөллийг Газрын даргын зөвлөл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 01/1383 дугаар албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.</p>	<p>Жилийн эцэст, төсвийн төслийг хянан Газрын даргын зөвлөлийн болон НДҮЗ-ийн гишүүдийн саналыг тусган Нийгмийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу 2023 оны 8 дугаар сарын 1-ний дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн</p>	<p>Нийгмийн даатгалын сангийн 2024-2026 оны төсвийн хүрээний мэдэгдлийн саналыг НДЕГ-ын даргын 2023 оны 01/493 дугаар албан бичгээр, жилийн хязгаарын саналыг 01/1059 дүгээр албан бичгээр тус тус ХНХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>НДҮЗ-ийн 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг хэлэлцүүлэн, НДЕГ-ын 2023 оны 01/1479 дүгээр албан бичгээр ХНХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Уг төсвийн төсөлд нийгмийн даатгалын багц хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан 2024 оноос хэрэгжих сангийн</p>	100

					байна.	орлого, зарлагын нөлөөллийн, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний нөлөөллийн, цалин, тэтгэврийг нэмэгдлийн нөлөөллийг тус тус тооцон тусгасан болно.	
2.14.	Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2024 оны төсвийн аймаг, нийслэлийн нарийвчилсан хуваарийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах, сар, улирлын хуваарийг батлах, төв, орон нутгийн албадад хүргүүлэх;	Шаард лагагүй	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр батлуулан, хуваарийг Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлнэ.	2023 оны төсвийн аймаг, нийслэлийн нарийвчилсан хуваарийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, сар, улирлын хуваарийг батлан, төв, орон нутгийн албадад хүргүүлсэн.	2024 оны төсвийн аймаг, нийслэлийн нарийвчилсан хуваарийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр, сар, улирлын хуваарийг баталж төв, орон нутгийн албадад хүргүүлсэн байна.	Нийгмийн даатгалын сангийн төсвийн 2024 оны төсвийн сар, улирлын хуваарийг боловсруулан Төсвийн тухай хуульд заасан хугацаанд ХНХЯ-нд хүргүүлэхээр бэлтгэж байна. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37.14.2-т заасны дагуу аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс /газар/-үүдийн нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийн нарийвчилсан хуваарийг НДЕГ-ын даргын тушаалаар батлуулахаар бэлтгэл ажлыг хангасан ба 12 дугаар сард багтаан батлуулна.	100
2.15.	Нийгмийн даатгалын төв орон нутгийн албадыг нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны зардлын төсөв, төлөвлөгөө боловсруулах нэгдсэн удирдлага, мэргэжил,	Шаард лагагүй	Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудыг удирдлага, арга зүйгээр хангаж холбогдох чиглэлийг хүргүүлэн ажиллана.	Аймаг, дүүргээс ирүүлсэн нийгмийн даатгалын сангийн 2023-2025 оны төсвийн төслийг хянан нэгтгэж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдийн саналыг тусган 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хөдөлмөр, нийгмийн	Эхний хагас жилд аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдийг мэргэжил, арга зүйгээр ханган	Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөөлөл болон үйл ажиллагааны урсгал зардал, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын төсвийн төсөл, төсөөлөл боловсруулахад баримтлах зааврыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны	100

	арга зүйгээр ханган ажиллах;			хамгааллын яаманд хүргүүлсэн. Мөн нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсөвтэй холбоотой анхаарах асуудал, баримтлах чиглэлийг төв, орон нутгийн хэлтсүүдэд хүргүүлсэн.	ажилласан байна. Жилийн эцэст нийгмийн даатгалын төсөв, төлөвлөгөө хийгдсэн байна.	05 дугаар сарын 24-ний өдрийн “Заавар батлах тухай” А/78 дугаар тушаалаар шинэчлэн баталж, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэв.	
2.16.	Нийгмийн даатгалын салбарын статистик үзүүлэлтийг шинэчлэх, мэдээллийн сан бүрдүүлэх;	Шаард-лагагүй	Хагас, бүтэн жилийн статистик үзүүлэлтийн нэгтгэлийг шинэчлэн, нарийвчилсан үзүүлэлтээр боловсруулж, мэдээллийн сан бүрдүүлнэ.	2021 оны байдлаар статистик үзүүлэлтийг шинэчилсэн.	2022 оны үзүүлэлтээр шинэчилсэн байна.	Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, ажил олгогч, албан журмын болон сайн дурын даатгуулагчийн тоо, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ зэрэг тоон мэдээллийг аймаг, дүүргээр 2022 оны байдлаар шинэчлэн нийгмийн даатгалын статистик үзүүлэлтийн нэгтгэлийг шинэчлэв. Мөн Үндэсний статистикийн хорооноос баталсан маягтын дагуу 2022 он, 2023 оны эхний хагас жилийн байдлаар гаргасан мэдээллээр үзүүлэлтийн нэгтгэлийг баяжуулан ажиллав. Нийгмийн даатгалын сангийн сарын мэдээний тоймыг тухай бүр бэлтгэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын <a href="http://www.ndaatgal.mn">www.ndaatgal.mn</a> вэб сайтад байршуулан ажиллав.	100
2.17.	Нийгмийн даатгалын салбарын статистикийн мэдээллийн маягтыг шинэчлэхэд холбогдох саналыг боловсруулах;	Шаард-лагагүй	Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн тушаалаар баталсан Нийгмийн даатгалын салбарын статистикийн мэдээллийн маягтыг	Уг ажлын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний статистикийн хороотой хамтарсан уулзалтуудыг зохион байгуулж, гарсан саналыг тусган тодорхой бэлтгэл ажлыг хангаж ажилласан.	Маягтыг шинэчлэн боловсруулах саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.	Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны “Нийгмийн халамж, даатгалын салбарын статистикийн мэдээллийн маягт, түүнийг нөхөх зааврыг батлах тухай” А/137 дугаар тушаалаар баталсан нийгмийн даатгалын салбарын статистик мэдээллийн маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн	100

			шинэчлэх саналыг хүргүүлнэ.			батлуулах ажлын хүрээнд Үндэсний статистикийн хорооны саналыг тусган статистик мэдээллийн маягыг боловсруулж, НДЕГ-ын даргын 2023 оны 01/248 дугаар албан бичгээр ХНХЯ-нд хүргүүлэв.	
<b>Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт</b>							
<i>“Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</i>							
3.1.	Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэх;	Шаардлагагүй	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлгээ хийж, тайланг хуулийн хугацаанд /02.15, 07.10-ны дотор/ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлнэ.	Үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 1/28, 01/1054 дугаар албан бичгээр болон цахимаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.	Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн явцад үнэлгээ хийгдэж хэрэгжилт биелсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад 2022 оны жилийг эцсийн байдлаар Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын нийт 52 шийдвэрийн 81 заалт байна. Хяналтад авсан нийт 52 шийдвэрээс: - 9 шийдвэр нь 2021 онд гарсан; - 43 шийдвэр нь 2022 онд шинээр хяналтад авсан заалтууд байна.  Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн дэлгэрэнгүйг харуулбал: - Монгол Улсын Ерөнхий сайдын 2 захирамжийн 4 заалт бүрэн хэрэгжиж 100,0 хувийн биелэлттэй; - Монгол Улсын Засгийн газрын тогтоолын 21 шийдвэрийн 30 заалтаас 13 шийдвэрийн 20 заалт бүрэн хэрэгжиж, 2 шийдвэрийн 2 заалт 90 хувийн	100

					<p>биелэлттэй,  - Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх боломжгүй хасуулах саналтай 2 шийдвэрийн 2 заалт, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 6 шийдвэрийн 6 заалт;  - Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 18 шийдвэрийн 26 заалтаас, 13 шийдвэрийн 20 заалт бүрэн хэрэгжиж, Нийгмийн даатгалын байгууллагад хамааралгүй байгаа тул хасуулах саналтай 2 шийдвэрийн 3 заалт, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 3 шийдвэрийн 3 заалт;  - Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар 1 шийдвэрийн 1 заалт бүрэн хэрэгжиж 100,0 хувийн биелэлттэй;  - Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 7 тогтоолын 17 заалт бүрэн хэрэгжиж 100,0 хувийн биелэлттэй;  - Бусад хамтарсан тушаалын 3 заалт бүрэн хэрэгжиж 100,0 хувийн биелэлттэй;</p> <p>2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад 2023 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл нийт 17 шийдвэрийн 28 заалт байна.</p> <p>Хяналтад байгаа нийт 17 шийдвэрийн 7 шийдвэр нь 2022 онд гарсан, 10 шийдвэр нь 2023 онд шинээр хяналтад авсан</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>заалтууд байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Засгийн газрын тогтоолын 13 шийдвэрийн 23 заалтаас, 6 шийдвэрийн 12 заалт бүрэн хэрэгжиж, 2 шийдвэрийн 2 заалт 90 хувийн биелэлттэй, 2 шийдвэрийн 4 заалт 70 хувийн биелэлттэй</li> <li>- Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх боломжгүй хасуулах саналтай 1 шийдвэрийн 1 заалт, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 1 шийдвэрийн 2 заалт, хэрэгжүүлэх боломжгүй 1 шийдвэрийн 2 заалт;</li> <li>- Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 4 шийдвэрийн 5 заалтаас 2 шийдвэрийн 2 заалт бүрэн хэрэгжиж, 1 шийдвэрийн 2 заалт 90 хувийн биелэлттэй хэрэгжүүлэх боломжгүй 1 шийдвэрийн 1 заалт байна.</li> </ul> <p>Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар 90,2 хувьтай үнэлж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2023 оны 01/355 дугаар албан бичгээр, 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт заалт бүрэн хэрэгжсэн бөгөөд биелэлтийн дундаж дүн 94,3 хувьтай үнэлж Нийгмийн даатгалын ерөнхий</p>	
--	--	--	--	--	---	--

						газрын даргын 2023 оны 01/355 дугаар албан бичгээр тус тус Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.	
3.2.	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;	Шаард-лагагүй	Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг /01.01, 06.15-ны дотор/ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 1/188 дугаар албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийгмийн даатгалын талаар тусгасан арга хэмжээ үе шаттай биелсэн байна.	<p>Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр 1 зорилт бүхий 1 арга хэмжээ тусгагдсан байна.Үүнд:</p> <p>Зорилт 1.5. <i>“Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүч бэлтгэж, ажлын байрыг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, нийгмийн хамгааллыг зорилтот бүлэгт чиглүүлж, халамжаас хөдөлмөрт шилжих оновчтой бодлого хэрэгжүүлнэ”</i> зорилтын хүрээнд:</p> <p>1.5.5. Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтоох /ЗГҮАХ-2.5.5/;</p> <p>Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2023 оны</p>	100

						эхний хагас жилийн байдлаар 100 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 01/1218 дугаар албан бичгээр Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.	
3.3.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;	Шаардлагагүй	Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг /01.01, 07.01-ны дотор/ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 1/123, 1/1189 дугаар албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийгмийн даатгалын талаар тусгасан арга хэмжээ үе шаттай биелсэн байна.	<p>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад 2023 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн.</p> <p>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр “Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд 5 зорилт бүхий 8 арга хэмжээ тусгагдсан байна.Үүнд:</p> <p>- 2.5.1. “Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжинэ.” зорилтын хүрээнд 3 арга хэмжээ;</p> <p>- 2.5.2.“Нийгмийн даатгалын</p>	100



					<p>шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцлийг бүрдүүлнэ” зорилтын хүрээнд 1 арга хэмжээ;</p> <ul style="list-style-type: none"><li>- 2.5.4. “Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ” зорилтын хүрээнд 1 арга хэмжээ;</li><li>- 2.5.5. “Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ” зорилтын хүрээнд 2 арга хэмжээ;</li><li>- 2.5.6. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй болгоно” зорилтын хүрээнд 1 арга хэмжээ;</li></ul> <p>Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2023 оны эхний хагас жилийн байдлаар 92.5 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 01/1345 дугаар албан бичгээр Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын</p>	
--	--	--	--	--	---	--

						яаманд хүргүүлсэн. 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ үнэлгээг хийж, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэх хугацаа болоогүй байна.	
3.4.	Монгол Улсыг (2021-2025) хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;	Шаард-лагагүй	Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 1/2468 албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.	Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нийгмийн даатгалын талаар тусгасан арга хэмжээ үе шаттай хэрэгжсэн байна.	Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэх хугацаа болоогүй байна.	Хугацаа болоогүй.
3.5.	"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;	Шаард лагагүй	Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлнэ.	-	Нийгмийн даатгалын талаар тусгагдсан зорилт, арга хэмжээ үе шаттай хэрэгжсэн байна.	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад 2023 оны эхний 8 сарын байдлаарх холбогдох мэдээ, мэдээллийг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт 2023 онд нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр "Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх,	100

					<p>Нэгдүгээр үе шат /2021-2023/-ны хүрээнд хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 1 зорилт бүхий 7 арга хэмжээ тусгагдсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэд, малчдыг нийгмийн даатгалд даатгуулах тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.;</li> <li>- Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.;</li> <li>- Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлж, төрийн болон хувийн тэтгэврийн сангаас тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг дэмжинэ.;</li> <li>- Нийгмийн даатгалын мэдээллийн системийг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулна.;</li> <li>- Нутгийн захиргааны байгууллагатай хамтран өрхийн болон хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг нийгмийн даатгалд заавал даатгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийнэ.;</li> <li>- Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлно.;</li> <li>- Тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжүүлж, 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгоно.;</li> </ul> <p>Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2023 оны</p>	
--	--	--	--	--	---	--

						эхний хагас жилийн байдлаар 95.0 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 01/1785 дугаар албан бичгээр Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.	
3.6.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;	Шаард лагагүй	Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж тайланг 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Тамгын газарт хүргүүлнэ.	Үнэлгээний тайланг 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Тамгын газарт хүргүүлсэн болно.	Нийгмийн даатгалын талаар тусгагдсан зорилт, арга хэмжээ үе шаттай хэрэгжсэн байна.	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны ажлын төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.</p> <p>Тус төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр 6 зорилтын 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.</p> <p>Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг харуулбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Үр дүнтэй” зорилт арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан буюу 100 хувийн биелэлттэй 12 арга хэмжээ;</li> <li>- “Тодорхой үр дүнд хүрсэн” зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай 70-99 хувийн биелэлттэй 4 арга хэмжээ;</li> <li>- Үнэлэх боломжгүй 4 арга хэмжээ байна.</li> </ul> <p>2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажил үүргийг зохих түвшинд биелүүлсэн тул</p>	100

						төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар 96,7 хувь буюу “Бүрэн хангалттай” гэж үнэлж, танилцуулгыг Тамгын газарт хүргүүлсэн.	
<p><b>“Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b></p>							
3.7.	Нийгмийн даатгалын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд шалгах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, үр дүнг тооцож ажиллах;	45.9 сая	Чингэлтэй, Сүхбаатар дүүрэг, Булган, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Ховд аймгийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулж ажиллана.	Нийгмийн даатгалын тухай хууль, хууль тогтоомжийн хэрэгжилтэд Баянзүрх дүүрэг, Өвөрхангай, Сүхбаатар, Төв аймгуудын Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож, 71.2 хувийг барагдуулж ажилласан.	Нийгмийн даатгалын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, үр дүнг тооцсон байна. /Улсын байцаагчийн актаар тогтоосон төлбөрийн 70-аас дээш хувийг барагдуулж ажилласан байна.	Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг Завхан, Өмнөговь, Булган, Сэлэнгэ, Архангай аймгууд болон Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст шалгалаа. Шалгалтаар 2018 оноос хойш хугацаанд шинээр тэтгэвэр тогтоолгон авсан нийт 29,6 мянган иргэний тэтгэврийн тогтоолтыг шалгаж 107 иргэнд үндэслэлгүй баримтаар тэтгэвэр тогтоож, олгосон 836,8 сая төгрөгийн зөрчил илрүүлэн нөхөн төлүүлэхээр шийдвэрлэж нийт төлбөрийн 75,1 хувь буюу 628,6 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд төлүүлээд байна. Мөн давхардсан тоогоор 113,1 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийн олголтыг мэдээллийн нэгдсэн сантай тулган шалгаж 23 иргэнээр илүү олгосон 13,6 сая төгрөгийг нөхөн төлүүлж, 21 иргэнд дутуу тооцож олгосон 10,6 сая төгрөгийг нөхөн олгохоор шийдвэрлэж зөрчлийг 100 хувь барагдуулж ажилласан. Эрүүгийн цагдаагийн албатай хамтран нүүрс тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг нэр бүхий 55 байгууллагын үйл ажиллагаанд	90

					<p>Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж 4304 даатгуулагчид олгосон 12,1 тэрбум төгрөгийн цалингийн сангаас 2843,4 сая төгрөгийн шимтгэл дутуу тооцсон зөрчил илрүүлэн, 50,0 саяас дээш төгрөгийн зөрчилтэй нэр бүхий 8 байгууллагыг Эрүүгийн тухай хуулиар, бусад 47 байгууллагыг Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу хариуцлага тооцохоор шийдвэрлэсэн.</p> <p>Мөн газрын даргын баталсан удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын болон Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авч байгаа иргэдийн тэтгэврийн давхардлыг 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд шалгаж 280 тэтгэвэр авагчтай холбоотой 184,2 сая төгрөгийн зөрчил илрүүлж 7 иргэнээр 2,6 сая төгрөгийг Нийгмийн даатгалын санд 100 хувь төлүүлж, 273 иргэнээр 181,6 сая төгрөгийг Нийгмийн халамжийн санд нөхөн төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоож, төлбөрийн 78,2 хувийг барагдуулаад байна.</p>		
3.8.	“Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулж, хамралтыг нэмэгдүүлэх” аяныг зохион байгуулж, дүнг нэгтгэн, үр дүнг тооцох;	12.0 сая	Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 30 хүртэл хувиар бууруулж, хамралтыг 10-аас дээш хувиар нэмэгдүүлнэ.	-	Улсын хэмжээнд авлагыг 30 хүртэл хувиар бууруулж, хамралтыг 10-аас дээш хувиар нэмэгдүүлсэн	Удирдамжийн дагуу хуримтлагдсан авлагыг бууруулж хамралтыг нэмэгдүүлэх аяны хүрээнд 2022 оны жилийн эцсээр нийт 31,4 мянган аж ахуйн нэгж, байгууллагаас 354.0 тэрбум төгрөгийн шимтгэлийн авлагатай байсан бөгөөд тайлант онд нийт авлагын хэмжээ 428,1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 327,3 тэрбум	90

					байна.	<p>төгрөгийг барагдуулсан боловч энэ оны авлагын үлдэгдэл 454,6 тэрбум болж оны эхний үлдэгдлээс 28,0 хувиар өссөн бөгөөд нийт авлагын 80,5 хувийг нийслэлийн 9 дүүргийн авлага эзлэж байна.</p> <p>Хяналт шалгалтын газраас хийсэн төлөвлөгөөт шалгалтын хүрээнд шалгалтад хамрагдсан аймаг, дүүргийн 120 ба түүнээс дээш хоногийн хурамтлагдсан өртэй 56 аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох албан тушаалтантай уулзаж 39 байгууллагын 398,3 сая төгрөгийн авлагыг шалгалтын хугацаанд барагдуулж ажилласан.</p> <p>Нийт авлагын оны эхний үлдэгдлийг Хэнтий аймаг 22,1 хувиар, Багануур дүүрэг 3,4 хувиар тус тус бууруулж ажилласан бол бусад аймаг, дүүргийн хэмжээнд 1-2,5 дахин нэмэгдүүлсэн түүнчлэн Завхан аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 3 дахин нэмэгдүүлсэн байна.</p>	
3.9.	Хяналт шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээг гаргуулан нэгтгэж, үр дүнг тооцож ажиллах;	Шаард лагагүй	Хяналт шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутамд гаргуулан нэгтгэж үр дүнг тооцож ажиллана. /Зөрчлийн 70-аас дээш хувийг	Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтад хяналт тавьж үр дүнг тооцон, илэрсэн зөрчлийн 71.2 хувийг барагдуулж ажилласан.	Шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг хагас жилийн болон жилийн эцсийн байдлаар гаргуулан	<p>2023 оны жилийн эцсийн байдлаар 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд дотоодын хяналт, шалгалтаар нийт 12,9 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж нийт зөрчлийн 91,4 хувь буюу 11,8 тэрбум төгрөгийг барагдуулж ажилласан байна.</p> <p>Тайлант хугацаанд илэрсэн нийт зөрчлийн 55,8 хувь буюу 7,2 тэрбум нь уг сангаас илүү тооцож олгосон тэтгэврийн зөрчил байгаа бол нийт зөрчлийн 85,2 хувь буюу</p>	90

			барагдуулна./		<p>нэгтгэж, төлбөр, зөрчлийн 70-аас дээш хувийг барагдуулж ажилласан байна.</p> <p>6,1 тэрбум нь үндэслэлгүй баримтаар шүүхийн шийдвэр гаргуулан тэтгэвэр тогтоолгон авсан мөн архивын лавлагааг хуурамчаар үйлдсэн зэрэг зөрчил байна.</p> <p>Тэтгэврийн даатгалын сангаас Аж ахуйн нэгж, байгууллага иргэд, даатгуулагчтай холбоотой 741 зөрчлийн шинжтэй үйлдлийг шалгаснаас орон нутагт 332, нийслэлд 409 аж ахуйн нэгж, байгууллага, иргэд даатгуулагч хамрагдлаа.</p> <p>Нийт зөрчлийн 87,0 буюу 644 зөрчлийг хялбаршуулсан журмаар, 11,2 хувь буюу 83 гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, 0,5 хувь буюу 4 зөрчлийг харьяаллын дагуу шилжүүлж, 1,3 хувь буюу 10 зөрчлийн хэрэгт 1,8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр тогтоосноос 599,9 сая төгрөгийн төлбөрийг орон нутагт, 1,2 тэрбум төгрөгийн төлбөрийг нийслэлд шалган тогтоож, нийт төлбөрийн 72,2 хувь буюу 1,2 тэрбум төгрөгийг барагдуулаад байна.</p> <p>Дээрх 741 аж ахуйн нэгж, байгууллагын 654 байгууллагад 234,0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч 98,2 хувийг барагдуулж ажилласан.</p>	
<i>Төрийн захиргаа, хүний нөөц.</i>						



3.10	<p>Нийгмийн даатгалын байгууллагын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөг боловсруулж батлах, хэрэгжилтэд хяналт тавих;</p>	<p>Үйл ажиллагааны зардлаар</p>	<p>Ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж батлуулна.</p>	<p>Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу давхардсан тоогоор нийт 357 албан хаагчид 48 200 000 төгрөгийн буцалтгүй тусламж олгож 100 хувь биелсэн.</p>	<p>Нийгмийн даатгалын байгууллагын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, бодит тусламжийг үзүүлсэн байна.</p>	<p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны баталсан “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-г 2 зорилтын хүрээнд 18 ажил үйлчилгээг тусгаснаас 17 ажил үйлчилгээ хөтөлбөрийн дагуу хэрэгжиж байна.</p> <p>Харин албан хаагчдын орон байрны нөхцөлийг сайжруулах, шинээр байр авахад хөнгөлөлт олгох асуудал Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор хэрэгжих боломжгүй байна.</p> <p>Тайлант хугацаанд буцалтгүй тусламж хүсэж өргөдөл гаргасан 129 (давхардсан тоогоор) албан хаагчид хууль тогтоомжийн дагуу судлан шийдвэрлэж 30.4 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон байна.</p>	100
3.11	<p>Ахмад настны нийгмийн баталгааг хангах, тусламж дэмжлэг олгох;</p>	<p>Ахмадын сангаас</p>	<p>Ахмад настны тухай хуулийн хүрээнд Ахмадын сангийн хөрөнгийг зарцуулах журмын хэрэгжилтийг хангаж ажиллана.</p>	<p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны А/09 дүгээр “Журам дүрэм шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралтаар баталсан “Ахмадын сангийн хөрөнгө зарцуулах журам”-д заасны дагуу 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 18,167,100 төгрөгийн буцалтгүй тусламжийг ахмад настнуудын ирүүлсэн өргөдөл хүсэлтийг үндэслэн олгосон.</p>	<p>Ахмад настнуудын нийгмийн баталгааг хангаж, холбогдох хууль журмын дагуу дэмжлэг тусламжийг олгож, Ахмадын хорооны 2023 оны хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан</p>	<p>НДЕГ-ын даргын 2019 оны А/09 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам”-д заасны дагуу ахмадууд хөнгөлөлт, тэтгэмж, зардлыг олгосон байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн улмаас эмчилгээ хийлгэх шаардлагатай 7 ахмад настанд 3.5 сая төгрөг;</li> <li>- Түлээ нүүрсний хөнгөлөлт болгон 2 ахмадад 600.0 мянган төгрөг;</li> <li>- Ахмад настнуудын явган аялалд дэмжлэг үзүүлж 50.0 мянган төгрөг;</li> </ul>	100

					батлуулж, хэрэгжилт 100 хувь хангагдсан байна.	- Дорноговь аймгийн Хамрын хийд рүү аялалд зориулж 30 ахмад настанд 8.1 сая төгрөг; - Сар шинийн баяраар 46 ахмад настанд 4.5 сая төгрөг; - Ахмадын баярыг тохиолдуулан 4.7 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон байна. Нийгмийн даатгалын ерөнхи газрын дэргэдэх Ахмадын хорооны 2023 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилт 100 хувьтай байна.	
3.12	Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авах, хянах, хадгалах, ХАСУМ, мэдэгдэл тайлбарыг гаргуулах, салбарын албан хаагчдын мэдүүлэг бүрдүүлэлтийн ажлын тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлэх;	Шаард лагагүй	Мэдүүлгийг хугацаанд нь гаргаж, тайлан мэдээг АТГ-т хуулийн хугацаанд хүргүүлнэ.	Салбарын хэмжээнд ХАСХОМ мэдүүлэх 720 албан хаагч байснаас 100 хувь буюу 720 албан хаагчийн 2021 оны ХАСХОМ гаргах ажлыг нийслэл, аймаг, дүүргийн 31 ЭБАТ-тай хамтран зохион байгуулсан. Үүнээс Нийгмийн даатгалын ерөнхий газрын 96 албан хаагчийн ХАСХОМ-ыг хугацаанд нь гаргуулж, баталгааны маягыг бүртгэсэн. Хуулийн хугацаанд буюу 2 дугаар сарын 28-нд ХАСХОМ-1, ХАСХОМ-2, ХАСХОМ-3, ХАСХОМ-4 тайлангуудыг салбарын хэмжээнд нэгтгэн гаргаж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.	ХАСХОМ-ыг салбарын хэмжээнд хуулийн хугацаанд 100% гаргасан байна.	Салбарын хэмжээнд ХАСХОМ мэдүүлэх 720 албан хаагч байснаас 100 хувь буюу 720 албан хаагчийн 2022 оны ХАСХОМ гаргах ажлыг нийслэл, аймаг, дүүргийн 31 ЭБАТ-тай хамтран зохион байгуулсан. Үүнээс: Нийгмийн даатгалын ерөнхий газрын 96 албан хаагчийн ХАСХОМ-ыг хугацаанд нь гаргуулж, баталгааны маягыг бүртгэсэн. Хуулийн хугацаанд буюу 2 дугаар сарын 28-нд ХАСХОМ-1, ХАСХОМ-2, ХАСХОМ-3, ХАСХОМ-4 тайлангуудыг салбарын хэмжээнд нэгтгэн гаргаж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 01/401 дүгээр албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. 2023 онд 27 албан хаагчийн ХАСУМ, их хэмжээний өөрчлөлт орсон-3, шинээр томилогдсон-26, албан тушаалтны ХАСХОМ-ийг	100

						хугацаанд нь гаргуулж АТГ-т хүргүүлсэн байна.	
3.13	Байгууллагын хэмжээнд авлигаас сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах, салбарын албан хаагчдад мэдээлэл, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;	Шаард лагагүй	Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан байна.	2022 оны 1 дүгээр сард ХАСХОМ-ийг хэрхэн гаргах талаар мэдээллийг өгөх зорилгоор 3 удаагийн сургалтыг зохион байгуулж салбарын хэмжээнд 300 гаруй албан хаагч хамрагдсан бол 2022 оны 10 дугаар сард Авлигатай тэмцэх газрын УССГХ-тэй хамтран цахимаар зохион байгуулсан сургалтад салбарын 400 гаруй албан хаагчийг хамруулсан байна.	Салбарын албан хаагчид авлига, ашиг сонирхлоос ангид байх нөхцөл хангагдаж сургалтад хамрагдсан байна.	2023 онд ХАСХОМ-ийг хэрхэн гаргах талаар мэдээллийг өгөх зорилгоор 2 удаагийн сургалтыг зохион байгуулж салбарын хэмжээнд давхардсан тоогоор 250 гаруй албан хаагч хамрагдсан. - 2023 оны 04 дүгээр сард салбарын “Архив, бичиг хэрэг, хүний нөөц хариуцсан албан хаагчдын сургалтад” “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь, ХАСУМ” сэдвээр сургалт зохион байгуулж сургалтад 156 албан хаагч хамрагдав. - 2023 оны 09, 10 дугаар сард Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд зохион байгуулсан сургалтын хөтөлбөрт “Авлига ашиг, сонирхлоос ангид байх” “Нийгмийн даатгалын ерөнхий газрын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх, тайланг бичих зааврын талаарх хичээлийг бэлтгэн салбарын хэмжээнд нийт 1400 албан хаагчийг хамруулсан байна.	100
3.14	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан захиргааны хэм хэмжээний актыг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэх;	Шаард лагагүй	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжиж буй боловч бүртгэгдээгүй захиргааны хэм хэмжээний актыг ангилан Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны	2022 онд захиргааны хэм хэмжээний 2 актыг бүртгүүлсэн.	- Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжиж буй боловч бүртгүүлээгүй захиргааны хэм	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны “Журам батлах тухай” А/31 дүгээр тушаалаар баталсан “Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам”-д Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2023 оны	100

			<p>төв байгууллагад бүртгүүлэн үйл ажиллагааг зохион байгуулна.</p>		<p>хэмжээний актыг ангилсан байна.</p> <p>- Захиргааны хэм хэмжээний актыг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлсэн байна.</p>	<p>“Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/59 дүгээр тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн 66 дугаар зүйл 66.1.1-д заасны дагуу журамд оруулсан нэмэлтийг хянуулж бүртгүүлэхээр холбогдох баримт бичгийн хамт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 01/927 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 1/2969 дугаартай албан бичгээр 2023 оны А/59 дүгээр тушаалыг үндэслэн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 5746 дугаарт бүртгэлтэй “Журам батлах тухай” 2022 оны А/31 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх хянах журам”-д оруулсан нэмэлтийг хүлээн авч, холбогдох хөдөлгөөн хийсэн.</p> <p>Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/139 дүгээр тушаалаар “Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журам”-ыг баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн боловч дахин нөлөөллийн шинжилгээ хийлгүүлэхээр буцаасан болно.</p>	
<p>Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын хөгжил, тогтвортой үйл ажиллагааг хангах.</p>							

3.15	<p>Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, шинээр байгуулах хэлэлцээрийн төсөл боловсруулах;</p>	<p>Шаардлагагүй</p>	<p>Хэлэлцээрийн дагуу хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.</p>	<p>-Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар "Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр"-ийг хэрэгжүүлэхэд ашиглах маягтын загваруудыг 2 тал албан ёсоор баталсан. -Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд ашиглах маягтын загваруудын саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв. - МУ, Бүгд Найрамдах Унгар Улсын хоорондын хэлэлцээрийн дагуу 28 иргэн тэтгэвэр тогтоолгох, ажилласан жил тооцуулах тухай өргөдөл, хүсэлт ирүүлсэн боловч, Унгар улсаас тэдгээр иргэдийн асуудлаар хариу ирүүлэхгүй байсан тул 26 иргэний сануулах маягыг Бүгд Найрамдах Унгар Улсын тэтгэврийн албанд цахимаар илгээсэн. Шинээр Монгол Улсын 2 иргэний тэтгэвэр Бүгд Найрамдах Унгар Улсаас тогтоогдов.</p>	<p>Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, зорилтот бүлэгт хүрч ажилласан байна.</p>	<p>1. Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хооронд байгуулсан "Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр"-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2. Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газар хооронд байгуулсан "Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр" албан ёсоор хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан иргэд даатгуулагчдад мэдээлэл өгөх танилцуулгыг <a href="http://www.ndaatgal.mn">www.ndaatgal.mn</a> веб болон нийгмийн даатгалын байгууллагын фэйсбүүк хуудсанд байршуулсан. Мөн БНЧУ-ын Нийгмийн хамгааллын байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын тэтгэврийн тогтолцооны талаар мэдээллийг англи хэл дээр бэлтгэж цахимаар хүргүүлэв. Тус хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган БНЧУ-ын нийгмийн даатгалын газарт MN/CZ 205 маягтаар 15 иргэн, MN/CZ 001 маягтаар 19 иргэн, MN/CZ 202 маягтаар 7 иргэний хүсэлтийг шуудангаар илгээсэн. 3. "Монгол Улс, Унгар Улс хоорондын нийгмийн хамгааллын хэлэлцээр"-ийн хэрэгжилтийн ханган тус улсаас тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан 13 иргэний MN/HU 001 маягт, 7 иргэний Монгол Улсад шимтгэл төлж ажилласан жилийг</p>	100
------	---	---------------------	---	---	--	---	-----

						<p>баталгаажуулах MN/HU205 маягт, 8 иргэний сануулах маягтыг тус тус гарган БНУУ-ын талд шуудангаар илгээв.</p> <p>4. “Монгол Улс, Бүгд Найрамдах Польш Улс, хоорондын нийгмийн хамгааллын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийн ханган тус улсаас тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан 2 иргэний хүсэлтийн маягт, 2 иргэний сануулах маягтыг тус тус БНПУ-ын талд шуудангаар илгээв.</p>	
3.16	<p>Бүгд Найрамдах Казахстан Улс болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг шинэчлэхтэй холбоотой тооцоо, судалгаа хийх, санал боловсруулах, сурталчлах;</p>	<p>Шаардлагагүй</p>	<p>Холбогдох тооцоо, судалгаа, саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлнэ.</p>	<p>Холбогдох ажлын хэсэгт ажиллаж, шаардлагатай тооцоо, судалгаа, саналыг хүргүүлэв.</p>	<p>Хэлэлцээрийг хэрэгжүүлэх чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран ажилласан байна.</p>	<p>Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хооронд “Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах хэлэлцээр”-ийн төсөл боловсруулах шинжээчдийн багийн 14 дэх удаагийн уулзалтад 11 дүгээр сард оролцож, холбогдох судалгаа, тооцоолол, хэлэлцээрт тусгах саналаа харилцан солилцов.</p>	100
3.17	<p>БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай Засгийн Газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд иргэдийн ажилласан хугацааг баталгаажуулах;</p>	<p>Үйл ажиллагааны зардлаар</p>	<p>БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд 1981 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр байгуулсан “Нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллана.</p>	<p>2022 онд нийт 69 иргэний хүсэлтийг холбогдох улсын тэтгэврийн санд албан бичгээр хүргүүлэв. Аж ахуйн нэгж байгууллагад 101 иргэний материалыг албан бичгээр хүргүүлсэн. 98 иргэнийг хүлээн авч мэдээлэл зөвлөгөө өгсөн.</p>	<p>Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн лавлагааг баталгаажуулах ажлыг зохион байгуулсан байна.</p>	<p>БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд Монгол Улсаас ОХУ-д ажилласан хугацааг баталгаажуулах хүсэлт гаргасан иргэд, ОХУ-ын тэтгэврийн фондоос ирүүлсэн ажилласан жил баталгаажуулахыг хүссэн иргэдийн хүсэлтийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн шийдвэрлэж байна.</p> <p>2023 оны эхний 11 сарын</p>	100

					<p>байдлаар 88 иргэний хүсэлтийг холбогдох улсын тэтгэврийн санд албан бичгээр хүргүүлэн шийдвэрлэсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"><li>1. Монгол Улсад ажил хөдөлмөр эрхэлж байгаа болон эрхэлж байсан ОХУ-ын 52 иргэний материалтай танилцан шийдвэрлэж, ОХУ-ын тэтгэврийн фондруу,</li><li>2. Монгол Улсад албан ёсоор оршин суудаг ОХУ-ын 1 иргэнийн материалыг ОХУ-ын тэтгэврийн фондруу,</li><li>3. ОХУ-д албан ёсоор оршин суудаг болон ОХУ-д ажиллаж байсан Монгол Улсын 14 иргэний материалыг хүлээн авч холбогдох байгууллага болон ОХУ-ын тэтгэврийн фондруу тус тус хүргүүлсэн.</li><li>4. Монгол Улсад ажиллаж байсан Украин Улсын 21 иргэний материалыг хүлээн авч холбогдох байгууллагад албан бичиг хүргүүлсэн.</li><li>5. Иргэний ажилласан жилийг баталгаажуулах зорилгоор Үндэсний Төв архив, Нийслэлийн архивын газар, Дорнод, Дархан-Уул аймгийн архивын тасаг, харьяа нийгмийн даатгалын хэлтсүүд, МУБИС, ШУТИС, Эрэл дунд сургууль, Улаанбаатар Төмөр зам, Алтан Дорнод ХХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ зэрэг байгууллагуудад ажилласан жилийн тодорхойлолт хүссэн 76 иргэний албан бичгийг хүргүүлэн шийдвэрлэсэн.</li></ol>	
--	--	--	--	--	--	--

						Тайлант хугацаанд 101 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгсөн.42 иргэнээс хүсэлт ирүүлснээс 38 иргэний хүсэлтийг холбогдох улсын тэтгэврийн санд албан бичгээр хүргүүлэн 96 хувийн гүйцэтгэлтэй байна. шийдвэрлэсэн.	
3.18	Олон улсын байгууллагатай хамтран ажиллах болон гэрээ, хэлэлцээр байгуулах, хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдаж буй ажлын бэлтгэл хангах;	Үйл ажиллагааны зардлаар	Гадаад улсын ижил төрлийн байгууллага, олон улсын болон бусад байгууллагатай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын сайдын тогтоосон журмыг үндэслэн гэрээ, хэлэлцээр байгуулж хамтран ажиллана.	БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба, Туркийн хамтын ажиллагаа зохицуулах агентлаг, Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ, Фредрих Эбертийн сантай хамтран ажиллах үйл ажиллагааны чиглэлүүдийг боловсруулан баталж, хамтран ажиллах саналыг албан бичгээр хүргүүлсэн.	Олон улсын байгууллага, донор байгууллагуудтай хамтран ажиллаж, өөрсдийн үйл ажиллагааг танилцуулж сурталчилсан байна. Хамтын ажиллагааны гарцын талаар санал солилцсон байна.	Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг /ТИКА/-тай хамтран ажиллах саналаа боловсруулан суурин төлөөлөгч Эмрах Устаөмэрт 2023 оны 01/911, 2023 оны цахим санал, 2023 оны 01/1629, 2023 оны 01/2077 дугаар албан бичгээр, Австрали Улсын Элчин Сайдын Яамны 2023 оны Хамтын ажиллагааг өргөжүүлэх тухай албан бичгийн хариуг боловсруулан Нэгдүгээр нарийн бичгийн дарга бөгөөд консул Ан Нүгэнд 2023. оны 01/932 дугаар албан бичгээр, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албаны Олон улсын харилцааны төвийн ерөнхий захирал Чимуг Кимд 2023 оны 01/1805 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-тай 2023 оны 01 дүгээр сард уулзалт зохион байгууллаа. Тус уулзалтаар 2016-2020 онд хэрэгжүүлсэн “Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх” техник туслалцааны төсөл болон 2020 оноос жил бүр зохион байгуулж байгаа “Санхүүгийн	100



					<p>шинжилгээний практик үйл ажиллагааны чадавхийг сайжруулах сургалт"-ын үр дүнгийн талаар ярилцаж, цаашид хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр харилцан санал солилцов.</p> <p>ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин Сайдын Яамны Консулын хэлтсийн эрхлэгч, зөвлөх Жукова Мария Евгеньевна, Консулын ажилтан Жажинов Николай Сергеевичтэй 2023 оны 03 дугаар сард уулзалт зохион байгууллаа.</p> <p>Уулзалтаар БНМАУ, ЗСБНХУ хооронд нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн хэрэгжилт болон хэлэлцээрийн шинэчилсэн төслийн талаар харилцан ярилцаж санал солилцов.</p> <p>Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг /ТИКА/-тай 2023 оны 05 дугаар сард уулзалт зохион байгуулсан.</p> <p>Уулзалтаар хамтран ажиллах талаар харилцан саналаа солилцож, НДЕГ-аас хамтран хэрэгжүүлэх төслийн саналаа эрэмбэлэн боловсруулж хүргүүлэхээр болсон.</p> <p>Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг /ТИКА/-тай хамтран ажиллах саналаа дараах 3 чиглэлээр боловсруулан 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр цахимаар хүргүүлсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"><li>1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын сургалтын танхимын эд хогшлыг шинэчлэх, цахим сургалтын тоног</li></ol>	
--	--	--	--	--	--	--

						<p>төхөөрөмж сайжруулах /25,000 ам доллар/ /нэн шаардлагатай/</p> <p>2. Нийгмийн даатгалын байгууллагын 7-10 албан хаагчийг БНТУ-д богино хугацааны сургалтад хамруулах /маш шаардлагатай/</p> <p>3. Явуулын үйлчилгээний тоноглогсон бага оврын автобус /шаардлагатай/</p> <p>НДЕГ-ын сургалтын танхимыг тохижуулах, сургалт явуулах орчин нөхцөл бүрдүүлэх зорилгоор сургалтын танхимын ширээ, сандал болон бусад тоног төхөөрөмжийг сайжруулах 70.2 сая төгрөгийн төсөв бүхий төслийн саналыг Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг /ТИКА/-т төслийн үнэлгээний загварын дагуу бөглөж 2023 оны 01/2077 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Тус төслийн дагуу сургалтын танхимын сандал 120, ширээ 40, хурлын ширээ 1, дугуйтай сандал 12, ухаалаг дэлгэц 1, микрофон 2 ширхэгийг тус тус хүлээн авлаа.</p> <p>Нийгмийн даатгалын байгууллагын “Танилцуулга 2023” номыг шинэчлэн боловсруулж, англи хэл дээр орчуулан хэвлүүлэв.</p>	
<i>Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.</i>							
<b>“Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b>							
4.1.	ISO 9001:2015 олон улсын стандартад нийцсэн чанарын удирдлагын тогтолцоог	-	Стандартыг мөрдөн ажиллах, чанарын удирдлагын тогтолцоонд шилжих,	2018 онд Төв, Орхон, 2019 онд Архангай, Дархан-Уул, Өвөрхангай, Хөвсгөл, 2020 онд Сонгинохайрхан дүүрэг болон	Жилийн эцэст Нийгмийн даатгалын ерөнхий	1. Стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс “Монголын бүтээмжийн төв”-тэй	50

	<p>нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;</p>		<p>нэвтрүүлэх ажлын явцыг хянаж, удирдлага, арга зүйгээр хангана.</p>	<p>Баян-Өлгий, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, 2021 онд Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс болон Булган, Дорноговь, Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтсүүд үйл ажиллагаандаа Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэн батламжаа гардан авсан.</p>	<p>газар, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Увс аймаг, Багануур, Баянгол, Налайх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн үйл ажиллагаанд ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлсэн байна.</p>	<p>хамтран “Стандартын ойлголт, үр дүн, ач холбогдлын талаарх” сургалтад хэлтсийн нийт 60 албан хаагч, Дорнод аймгийн нийгмийн даатгалын хэлтэс “Менежмент ба ур чадварын академи”-аас зохион байгуулсан Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015, Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO27001:2018, Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO45001 стандартын сургалтад 23 албан хаагчдыг тус тус хамруулсан байна.</p> <p>2. Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь үйл ажиллагаандаа Чанарын менежментийн тогтолцооны ISO9001:2015 (MNS9001:2016) стандартыг энэ оны 7 сард нэвтрүүлэн батламж авсан.</p> <p>3. Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн албан хаагчдад 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001 стандартын талаар танилцуулга сургалт болон магадлан аудитад хэрхэн бэлтгэх талаар сургалт зохион байгуулсан бөгөөд тус сургалтад 26 албан хаагч хамрагдав.</p> <p>Мөн Тус хэлтсийн үйл ажиллагаанд 11 дүгээр сарын 09-ний өдөр “Чанарын дотоод аудит”-ыг гүйцэтгэж, Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь</p>	
--	---	--	---	--	--	--	--

						Чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015 стандартын хэрэгжилтэд магадлан аудит хийлгэж стандартын шаардлага хангаж батламжийн хугацаагаа сунгав.	
4.2.	Иргэд, даатгуулагч, ажил олгогчдод нийгмийн даатгалын талаарх мэдээлэл, зөвлөгөө өгөх;	-	Нийгмийн даатгалын тухай холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгон иргэд даатгуулагчдад мэдээлэл, зөвлөгөө өгнө.	-Нийгмийн даатгалын ерөнхий газраас иргэдэд мэдээлэл зөвлөгөө өгөх зорилготой Фэйсбүүк хуудсыг 29,765 иргэн дагаж байгаа бөгөөд давхардсан тоогоор нийгмийн даатгалын талаарх мэдээлэлтэй танилцсан 1,508,369, эргэж холбогдсон 134,093, сэтгэгдэл үлдээсэн 4,734, бусдад түгээсэн 10,404 иргэн байна. Чатаар зурвас илгээсэн 15,660 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгсөн. -“Нийгмийн даатгал” гар утасны апплейкшнээр дамжуулж 5,085 иргэнд, ndaatgal.mn цахим хуудасны санал хүсэлт булангаар 178 иргэн, даатгуулагчид мэдээлэл зөвлөгөөг өгч ажилласан байна.	Иргэдэд цахим хэлбэрээр мэдээлэл зөвлөгөө хүргэх хүрээг өргөтгөн, дагагчдын тоог нэмэгдүүлсэн тэднийг нийгмийн даатгалтай холбоотой шинэ мэдээ, мэдээллээр тогтмол хангаж ажилласан байна.	2023 оны эхний 11 сарын байдлаар Фэйсбүүк хуудсыг 32.3 мянган иргэн дагаж байгаа бөгөөд давхардсан тоогоор нийгмийн даатгалын талаарх мэдээлэлтэй танилцсан 258.3 мянган, эргэж холбогдсон 1,853 сэтгэгдэл үлдээсэн 156, бусдад түгээсэн 589 иргэн байна. Чатаар зурвас илгээсэн 1,853 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгсөн. “Нийгмийн даатгал” гар утасны апплейкшнээр дамжуулж 7,378 иргэнд, ndaatgal.mn цахим хуудасны санал хүсэлт булангаар 35 иргэн, даатгуулагчид мэдээлэл зөвлөгөөг өгч ажилласан байна.	100
<b>“Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b>							
4.3.	Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх;	27.3 сая	Нийгмийн даатгалын байгууллагын 2023 оны сургалтын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	Албан хаагчдыг чадавхижуулах, ур чадварыг дээшлүүлэх 1,046 удаагийн сургалтад 21,678 (давхардсан тоогоор) албан хаагчийг хамруулсан.	2023 онд албан хаагчдыг чадавхижуулах сургалтын төлөвлөгөөг боловсруулан баталж, цахим болон танхимын	Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын хэмжээнд албан хаагчдыг чадавхижуулах, ур чадварыг дээшлүүлэх <b>774</b> удаагийн сургалтад <b>15,918</b> албан хаагчийг хамруулсан.	100

					хэлбэрээр сургалтыг зохион байгуулсан байна.		
4.4.	Ажил олгогч, даатгуулагч, иргэдийн нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтын агуулга бий болгох, хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах;	11.7 сая	2023 онд ажил олгогч, даатгуулагч, иргэдэд чиглэсэн нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаарх сургалтын агуулга, хөтөлбөр батлагдаж, сургалт зохион байгуулж ажиллана.	Салбарын хэмжээнд ажил олгогч, иргэд даатгуулагчдад чиглэсэн 3,299 удаагийн танхимын болон цахим сургалтад 241,533 иргэд, даатгуулагчийг хамруулсан. Мөн 892 удаагийн явуулын үйлчилгээнд 94,677, 187 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөгт 51,706 иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын талаар зөвлөгөө мэдээлэл хүргэн ажиллалаа.	Ажил олгогч, иргэд даатгуулагчийн нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаарх ойлголтыг дээшлүүлэх зорилтот сургалт, арга хэмжээг зохион байгуулсан байна.	Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын хэмжээнд ажил олгогч, иргэд даатгуулагчид чиглэсэн <b>2,266</b> удаагийн танхимын болон цахим сургалтад <b>220,885</b> иргэд, даатгуулагчийг хамруулав. Мөн салбарын хэмжээнд 240 удаагийн явуулын үйлчилгээнд 71,032 иргэд даатгуулагч, 122 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөгт 18,852, нийт <b>362</b> удаагийн арга хэмжээнд <b>89,844</b> иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав.	100
4.5.	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангах;	40,0 сая (Мэдээлэл сурталчилгааны зардал)	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хийх сурталчилгаа, мэдээллийн тоог өсгөж ажиллана.	81 хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан 578 удаагийн давтамжтайгаар нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд даатгуулагчдад хүргэж ажилласан.	Олон нийтэд хүргэх шаардлагатай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай дамжуулж, мэдээлэл авах хүсэлт гаргасан хэвлэл мэдээллийн байгууллагуудыг мэдээллээр хангасан байна.	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагаа болон цаг үеийн мэдээллийг олон нийтэд 86 /давхардсан тоогоор/ хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан 589 /давхардсан тоогоор/ удаагийн давтамжтайгаар хүргэж, хэвлэл мэдээллийн байгууллагыг эх сурвалж, мэдээллээр хангаж ажиллав.	100
4.6.	Нийгмийн даатгалын		Нийгмийн даатгалын	Нийгмийн даатгалын	Шинэ	Нийгмийн даатгалын хууль	100

	<p>хууль тогтоомж, ач холбогдол, үйл ажиллагаа, үйлчилгээг иргэдэд ойлгомжтой, шинэлэг байдлаар тайлбарласан контент бэлтгэн түгээх;</p>		<p>ач холбогдол, үйлчилгээг сурталчилсан контент, постер мэдээлэл бэлтгэн түгээнэ.</p>	<p>үйлчилгээний талаар 7 заавар, гарын авлага, 53 постер мэдээлэл, 4 шторк, 71 удаагийн цаг үеийн буюу нийт 133 удаагийн мэдээллийг бэлтгэн түгээсэн.</p>	<p>контентийн агуулга, хэлбэрийг тодорхойлон бэлтгэж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон сошиал сүлжээгээр нэвтрүүлэн иргэд (даатгуулагч), ажил олгогчид хүргэсэн байна.</p>	<p>тогтоомж, үйлчилгээ, цаг үеийн мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах хүрээнд <a href="http://www.ndaatgal.mn">www.ndaatgal.mn</a> вебсайт болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас болон @sigomongolia сошиал 8 хөдөлгөөнт постер, 44 постер мэдээлэл, 13 аудио, видео шторк, 57 цаг үеийн буюу нийт 122 удаагийн мэдээллийг бэлтгэн түгээсэн. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийгмийн даатгалын сан, үйлчилгээний мэдээллийг цувралаар хөдөлгөөнт постер хэлбэрээр бэлтгэн нийтэлж “Өндөр насны тэтгэвэр”, “Жирэмсний болон амаржсаны тэтгэмж”, “Тахир дутуугийн тэтгэвэр”, “Ажилгүйдлийн тэтгэмж”-ийн талаарх постер мэдээлэл 185,978 хүнд хүрч 63,032 хүн үзсэн бөгөөд 2348 удаа түгээгдсэн;</li> <li>- Тэтгэврийн зөрүү, итгэлцүүрийн талаарх мэдээлэл болон УИХ-аас баталсан Нийгмийн даатгалын багц хуулиудын талаарх шторк мэдээлэл 85,410 хүнд хүрч 79,410 хүн үзсэн бөгөөд 1540 удаа түгээгдсэн;</li> <li>- Эдгээр мэдээлэл давхардсан тоогоор 3.5 сая хүнд хүрсэн;</li> <li>- Нийгмийн даатгалын байгууллагын танилцуулга номыг шинэчлэн цахим хэлбэрээр түгээгдсэн;</li> <li>- Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга гарын авлагыг 7,5 мянган ширхэг хэвлэн хэвлэмэл</li> </ul>	
--	--	--	--	---	--	---	--

						<p>болон цахим хэлбэрээр түгээсэн.</p> <p>Иргэд, даатгуулагчдын санал хүсэлтэд шуурхай хариулах, эргэх холбоог хангах зорилгоор ажиллуулж байгаа @sigomongolia сошиал хуудасны чатбот мессенжерт нийт 43,379 иргэн мэдээлэл авахаар хандсанаас, автомат хариулагчаас 27,134 иргэн, цахим үйлчилгээний холбоос руу шилжсэн 1,912 иргэн байгаа бол 11 иргэн тухайлсан гомдол илгээснийг цаг тухайд нь шийдвэрлэж, 13,777 иргэн тухайлсан зөвлөгөө мэдээлэл авахаар хандсаныг шийдвэрлэн ажиллав.</p>	
<p><b>“Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b></p>							
4.7.	Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын хамтарсан болон дахин магадлалыг сонгогдсон аймаг, дүүрэгт зохион байгуулах;	47.7 сая	Засгийн газрын 2021 оны 67 дугаар тогтоолоор баталсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд хамтарсан болон дахин магадлалыг зохион байгуулж ажиллана.	2022 онд ЭХМТК-ын дахин магадлалыг Сүхбаатар дүүрэг болон Баян-Өлгий, Баянхонгор, Говьсүмбэр, Дорноговь, Сүхбаатар аймгуудад зохион байгуулсан.	Батлагдсан хуваарийн дагуу аймаг, дүүрэгт хяналт шалгалт зохион байгуулсан байна.	<p>Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дахин болон хамтарсан магадлалыг зохион байгуулав. Үүнд:</p> <p><b>Дахин магадлалыг</b> нийслэлийн Багануур дүүрэг болон Өвөрхангай аймагт зохион байгуулав.</p> <p>Дахин магадлалаар нийт 391 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг хэвээр магадлаж, 14 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох заалт өөрчлөх, онош эргэлзээтэй, заалт хувь, хугацаа зөрсөн, оношийн баталгаажилт хангалтгүй 28 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцлахаар шийдвэрлэв.</p>	100

						<p><b>Хамтарсан магадлалыг</b> хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгосон даатгуулагч (иргэн)-ийн тоогоор улсын дундаж (3.1%)-аас өндөр байгаа Сэлэнгэ, Хэнтий, Өмнөговь аймагт Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлүүдтэй хамтран зохион байгуулав.</p> <p>Хамтарсан магадлалаар хөдөлмөрийн чадвар алдсан 3282 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоосон байдалд хяналт шалгалт хийж, 2265 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэвээр магадлан, 292 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хугацааг сунган, 201 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж, 504 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, онош, заалтыг өөрчилж магадлав.</p>	
4.8.	“Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-д өөрчлөлт оруулах саналыг боловсруулах;	-	“Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-д заасны дагуу өөрчлөлт оруулах саналыг боловсруулан батлуулна.	2020 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн санал 2021 онд батлагдан хэрэгжсэн бөгөөд 2023 онд шинээр өөрчлөлт оруулах саналын төслийг боловсруулж байна.	Өөрчлөлт оруулах саналыг боловсруулан Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрмийг ХНХЯ-нд хүргүүлсэн байна.	<p>Засгийн газрын 2021 оны 67 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, эрүүл мэндийн байгууллагын Эмнэлэг хяналтын</p>	100



						<p>комиссын эмч, мэргэжилтнүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэн тус дүрмэнд 2 заалт шинээр нэмэх, 6 заалтад өөрчлөлт оруулах саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын “Санал хүргүүлэх тухай” 2023 оны 01/261 дугаар албан бичгээр ХНХЯ-ны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлэв.</p> <p>Мөн тус яамнаас 2023 оны 09 дүгээр сард уг дүрмийн төсөлд санал авахаар ирүүлсэн албан бичгийн дагуу дүрмийг дахин боловсруулж, саналыг ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 01/1656 дугаар албан бичгээр хүргүүлэв.</p>	
4.9.	“Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хувь хэмжээ, хугацаа”-нд өөрчлөлт оруулах саналыг боловсруулах;	-	“Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хувь хэмжээ, хугацаа”-нд өөрчлөлт оруулах саналыг боловсруулж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлнэ.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны А/758, А/197 дугаар тушаалаар “Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хувь хэмжээ, хугацаа”-г шинэчлэн батлуулж мөрдлөг болгон ажиллаж байна.	Өөрчлөлт оруулах саналыг боловсруулан “Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт”-ын төслийг ХНХЯ-нд хүргүүлсэн байна.	<p>Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/758, А/197 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт”-ыг хэрэгжүүлэх явцад иргэд (даатгуулагч) болон аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллага, Эмнэлэг хяналтын комисс, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдээс уг жагсаалтад өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа талаар санал ирүүлсээр байсан тул Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс нь жагсаалтад өөрчлөлт оруулах үндэслэлийг</p>	100

						<p>судлан, саналыг нэгтгэж 10 заалтыг шинээр нэмэх, 3 заалтыг хасах, 50 заалтад өөрчлөлт оруулахаар, нийт 63 саналыг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын даргын “Санал хүргүүлэх тухай” 36 дугаар албан бичгээр 2023 оны 04 дүгээр сард Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлэв.</p> <p>Мөн Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор уг жагсаалтыг дахин боловсруулж, ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 01/1662 дугаар албан бичгээр хүргүүлэв.</p>	
<p><b>“Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b></p>							
4.10	Салбарын хэвийн үйл ажиллагааг хангах ажлыг мэдээллийн технологиор дэмжин ажиллах;	-	Хууль тогтоомжид орсон өөрчлөлт болон шинээр батлагдсан хуулийн дагуу Нийгмийн даатгалын салбарын үйлчилгээг мэдээллийн дэвшилтэт технологид суурилан үзүүлж, үйлчилгээний хэвийн ажиллагааг хангана.	- Шинээр 3 систем нэвтрүүлсэн. - Ашиглагдаж буй 10 гаруй програм хангамжид нийт 110 орчим удаагийн өөрчлөлт, хөгжүүлэлт хийсэн.	2023 онд хэрэгжих хууль тогтоомжийн өөрчлөлтийг мэдээллийн технологид суурилан хэрэгжүүлэх зорилгоор одоо ашиглагдаж буй програм хангамжид өөрчлөлт оруулна. Шаардлагатай тохиолдолд	<b>Шинээр 3 систем боловсруулан нэвтрүүлэв.</b> 1. Даатгуулагч жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлтээ, мөн сайн дураар даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргах хугацаа дуусахаас 8 хоногийн өмнө сануулах мэдэгдлийг тухайн даатгуулагчийн гар утасны дугаар руу мессежээр илгээх “Message” системийг боловсруулан нэвтрүүлээ. Даатгуулагч уг мэдэгдлийн дагуу хүсэлтээ E-Mongolia портал, “Даатгуулагчдад зориулсан вэб” системийг	100

					<p>шинээр мэдээллийн систем боловсруулж нэвтрүүлсэн байна.</p>	<p>ашиглан цахимаар илгээх боломжтой бөгөөд одоогийн байдлаар нийтдээ 11.9 мянган даатгуулагчид сануулах мессежийг илгээсэн байна.</p> <p>2. Нийгмийн даатгалын шимтгэлийн цахим системд ажил олгогч шинээр цахимаар бүртгүүлэх боломжийг бүрдүүлж нэвтрүүллээ. Ингэснээр ажил олгогч нийгмийн даатгалын байгууллагад ирэлгүйгээр бүртгүүлэх хүсэлтээ цахимаар илгээж, системд нэвтрэх нэр, нууц үгийг цахимаар авах боломжтой. Ажил олгогчоос ирсэн хүсэлтийг нийгмийн даатгалын холбогдох албан тушаалтан хүлээн авч мэдээллийг шалгасны үндсэн дээр үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санд төлөх шимтгэлийн хувь хэмжээг тогтоож, баталгаажуулснаар нэвтрэх нэр, нууц үг илгээгдэж байна.</p> <p>3. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагч “Даатгуулагчид зориулсан вэб” систем болон E-Mongolia порталыг ашиглан онлайнаар шимтгэлээ төлөх боломжийг бүрдүүлж туршин тестэлж байна.</p> <p><b>Ашиглагдаж буй програм хангамжид 70 гаруй удаагийн өөрчлөлт, хөгжүүлэлт хийв.</b></p> <p>Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах болон хэрэглэгчийн хүсэлтээр ашиглагдаж буй</p>
--	--	--	--	--	--	---

					<p>програм хангамжид нийт 70 гаруй удаагийн өөрчлөлт, сайжруулалтыг хийж цаг тухай бүрд нь нэвтрүүлж салбарын тасралтгүй, хэвийн ажиллагааг мэдээллийн технологиор дэмжин ажиллалаа. Тухайлбал:</p> <p>1. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2022 оны 10 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шинэчлэн тогтоосонтой холбогдуулан Шимтгэлийн цахим систем, Шимтгэл, Тэтгэвэр, Тэтгэмж, Эрүүл мэндийн орлогын тооцооны програм хангамжууд, Сайн дурын онлайн систем, “Даатгуулагчдад зориулсан вэб”, “Нийгмийн даатгал” аппликейшн зэрэг програм хангамжуудад даатгуулагчийн сард төлөх шимтгэлийн доод хэмжээг 550.0 мянга, дээд хэмжээг 5,500.0 мянган төгрөгөөс тухайн даатгуулагчийн төрлөөс шалтгаалан шимтгэл тооцох хувь хэмжээгээр тооцохоор тохируулах;</p> <p>2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд:</p> <p>- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан болзол, нөхцөлөөр</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>2023 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны шалгуурыг эрэгтэй 61 нас 6 сар, эмэгтэй 56 нас 6 сар, шимтгэл төлөх хугацааны шалгуурыг 21 жил 6 сараар тохируулах өөрчлөлтийг тэтгэврийн тооцооны програм хангамжид хийв.</p> <p>3. <i>Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны “Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- Нас барсан даатгуулагчийн ар гэрт тэтгэмжийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжийн хэмжээг 2 сая төгрөг болгон өөрчлөх;</li> <li>- 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш амьгүй донор болж эд эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох оршуулгын тэтгэмжийн хэмжээг 3,5 мянган төгрөгөөр тохируулах.</li> </ul> <p>4. <i>Нийгмийн даатгалын тухай хууль, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Засгийн газрын 2023 оны 60 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, мөн ЦЕГ, ХБХЕГ зэрэг байгууллагуудын хүсэлтийн дагуу НДЕГ-ын даргын тушаалаар даатгуулагчийн 7 төрлийг шинэчлэн баталж шимтгэлийн</i></p>
--	--	--	--	--	--

					<p>хувь хэмжээг тохируулсан.</p> <p>5. Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай, “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” тогтоолуудын хэрэгжилтийг хангах хүрээнд дор дурдсан ажлуудыг гүйцэтгэн тэтгэврийн хэмжээг цаг хугацаанд нь нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>- “Тэтгэврийн тооцооны програм хангамж”-д нийт 14 төрлийн өөрчлөлтийг хийсэн;</li><li>- Тэтгэвэр авагч “Даатгуулагчид зориулсан вэб” системийг ашиглан 2023 оны 07 дугаар сарын 01-ний тэтгэврийн нэмэгдлийн мэдээлэл, шинэ итгэлцүүрээр өсгөсөн цалингийн мэдээллээ дэлгэрэнгүй харах нөхцөлийг бүрдүүлсэн.</li></ul> <p>6. “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль” шинэчлэн батлагдаж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжихтэй холбогдуулан дараах програм хангамжуудад өөрчлөлт, хөгжүүлэлт хийж тэтгэвэр авагч болон нийгмийн даатгалын байгууллагуудад ашиглах нөхцөлийг бүрдүүллээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>- Шинэчлэн батлагдсан хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалтын дагуу дараалсан 6, 7 жилийн цалин хөлсний дунджаас тэтгэврээ тогтоолгосон тэтгэвэр</li></ul>	
--	--	--	--	--	--	--

					<p>авагч тэтгэврээ 5 жилийн дундаж цалин хөлснөөс өөрчлөн тогтоолгох хүсэлтээ “Даатгуулагчид зориулсан вэб” систем болон <i>E Mongolia</i> порталыг ашиглан цахимаар илгээх боломжийг бүрдүүлсэн.</p> <p>- Тэтгэвэр авагчийн цахимаар илгээсэн тэтгэврээ өөрчлөн тогтоолгох хүсэлтийг Нийгмийн даатгалын байгууллага хүлээн авч тэтгэврийг нь өөрчлөн тогтоох хөгжүүлэлтийг “Тэтгэврийн тооцооны програм хангамж”-д хийж нэвтрүүлсэн.</p> <p>7. “Шимтгэлийн цахим систем”-д Гадаадын иргэн, харьяатын газраас олгож буй гадаад иргэдийн бүртгэлийн дугаарыг шинэчлэн бүртгэж авах боломжийг бүрдүүллээ. Үүнд:</p> <p>- ЮД буюу YUD регистрийн дугаартай гадаад иргэдийн регистрийн дугаарын формат шалгах;</p> <p>- Гадаадын иргэн, харьяатын газраас ЮД буюу YUD регистрийн дугаартай иргэдийн мэдээллийг сервисээр дуудан шалгах;</p> <p>- ЮД-гээс бусад 13 оронтой регистрийн дугаартай гадаад иргэдийн регистрийн дугаарын формат шалгах;</p> <p>- Гадаадын иргэн, харьяатын газраас ЮД-гээс бусад 13 оронтой регистртэй иргэдийн мэдээллийг сервисээр дуудаж шалгах.</p> <p>8. “Даатгуулагчийн үндсэн ажил олгогчоос гадна нэгээс</p>	
--	--	--	--	--	--	--

						дээш байгууллагад ажиллан илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох аргачлал"-ын дагуу 2022 оны илүү төлсөн шимтгэлээ буцаан авах эрх нь үүссэн нийт 15883 даатгуулагчийн мэдээллийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллийн санд байршуулж, даатгуулагчдад илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох боломжийг бүрдүүлсэн гэх мэт.	
4.11	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд мэдээллийн шинэчилсэн системийг турших, нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлэх;	-	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд мэдээллийн шинэчилсэн системийг нэвтрүүлнэ.	-	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд мэдээллийн шинэчилсэн системийг туршиж нэвтрүүлсэн байна.	- Мэдээллийн шинэчилсэн цогц системийг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд 4 “Ажлын хэсэг” байгуулж, нийгмийн даатгалаас иргэд даатгуулагчдад үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ тус бүрээр системд шалгалт хийх, тестлэх ажил хийгдэж байна. “Ажлын хэсэг” гүйцэтгэгч байгууллагатай 20 гаруй удаа, дотооддоо 30 гаруй удаагийн уулзалт зохион байгуулж, 2 портал, 6 дэд систем, 10 гаруй бүтээгдэхүүн үйлчилгээний програмчлалын явцтай танилцаж үйлдэл, цэс, цонх тус бүрээр нарийвчилсан коммент өгч ажилласан. Мөн тэтгэвэр, тэтгэмжийн 28 бүтээгдэхүүнд хуулийн дагуу тавигдах болзол нөхцөл, томьёоллыг шалгах 2.0 мянга гаруй шалгуур үзүүлэлтийг боловсруулж, нэг дүүргийн нэг улирлын бүх тохиолдлыг тестлэн шалгуур хангаж буй эсэхэд хяналт тавьж, сайжруулах саналыг гүйцэтгэгч байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэн	90



						<p>ажиллалаа.</p> <p>- Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд нэвтрүүлэх мэдээллийн шинэчилсэн системд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжих Нийгмийн даатгалын багц хуулийн 100 гаруй заалтын дагуу 300 орчим өөрчлөлт хөгжүүлэлтийг тусгах ажлыг гүйцэтгэж байна.</p> <p>- Салбарын хэмжээнд одоо байгаа мэдээллийн санг шинэчилсэн системд хөрвүүлэх загварчлалыг боловсруулан түүний дагуу нийт ажил олгогч, даатгуулагчийн цалин, шимтгэл төлөлт, тэтгэвэр, тэтгэмжийн мэдээллийн санг хөрвүүлэн оруулах, тохируулга хийх ажлыг гүйцэтгэсэн.</p> <p>Мэдээллийн шинэчилсэн цогц системийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн салбарын хэмжээнд үе шаттайгаар нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p>	
4.12	Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сан үүсгэж, төрийн мэдээллийн нэгдсэн сангаас нийгмийн даатгалын үйлчилгээг тогтвортой үзүүлэх;	-	<p>1. Нэгдсэн мэдээллийн санг 2023 оны мэдээллээр баяжуулна.</p> <p>2. Нэгдсэн мэдээллийн сангаас судалгаа мэдээллийн боловсруулалт хийнэ.</p> <p>3. Цахимаар үзүүлж буй нийгмийн даатгалын үйлчилгээний хэвийн ажиллагааг хангана.</p> <p>4. Төрийн</p>	<p>1. 82.3 GB нэгдсэн мэдээллийн сан үүссэн.</p> <p>2. 250 удаагийн мэдээллийн боловсруулалт хийсэн.</p> <p>3. Цахимаар үзүүлж буй нийгмийн даатгалын үйлчилгээ: -“Нийгмийн даатгал” аппликейшнийг 250.0 мянган даатгуулагч идэвхитэй ашигласан.</p> <p>-Даатгуулагч 3 сувгаар 2.4 сая удаа шимтгэл төлөлтийн QR кодтой лавлагаа тодорхойлолт авсан.</p>	<p>1. Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, нөөцлөх, төрийн нэгдсэн мэдээллийн санд байршуулах, нэгдсэн мэдээллийн сангаас үйлчилгээ</p>	<p><b>1. Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн санг баяжуулан хэвийн ажиллагааг ханган ажиллав.</b></p> <p>Төв, орон нутгийн нийгмийн даатгалын 30 нэгжийн мэдээллийн санг өдөр бүр цахимаар цуглуулан нэгтгэж нэгдсэн мэдээллийн санг үүсгэх ажлыг тогтмол хийж гүйцэтгэлээ.</p> <p>Энэ онд ажил олгогч, даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж авагчийн дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан <b>112.8GB</b> нэгдсэн</p>	100

		<p>байгууллагуудтай цахимаар мэдээлэл солилцох ажлыг өргөжүүлнэ.</p>	<p>-ТҮЦ машинаас 156.9 мянган лавлагаа тодорхойлолт хэвлэн авсан.          -E-mongolia төрийн цахим үйлчилгээний нэгдсэн порталаар нийгмийн даатгалын 11 төрлийн лавлагаа тодорхойлолтыг цахимаар хүргэсэн.          4. Цахимаар мэдээлэл солилцох төрийн байгууллагын тоог 2-оор нэмэгдүүлж, нийт 18 төрийн байгууллагад цахим мэдээлэл хүргүүлэх үйлчилгээ хэвийн явагдсан.</p>	<p>үзүүлэх ажил тогтвортой хийгдсэн байна.          2. Нэгдсэн мэдээллийн сангаас судалгаа мэдээллийн боловсруула лт хийх ажлыг цаг тухай бүр гүйцэтгэсэн байна.          3. Иргэд даатгуулагч, ажил олгогч, харилцагч байгууллагуу дад “Нийгмийн даатгал” аппликейшн, “Даатгуулагчид зориулсан вэб”, ТҮЦ машин, төрийн цахим үйлчилгээний e-mongolia нэгдсэн порталаар дамжуулан цахимаар үзүүлэх мэдээллийн үйлчилгээг өргөжүүлж, тогтвортой ажиллагааг</p>	<p>мэдээллийн сан нэмж үүссэн байна.  <b>2. Нэгдсэн мэдээллийн сангаас 200 гаруй удаагийн мэдээллийн боловсруулалт, судалгаа гаргав.</b>          Нийгмийн даатгалын нэгдсэн өгөгдлийн сангаас Нийгмийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлэг болон тэтгэврийн итгэлцүүрийг шинэчлэн тогтооход шаардагдах судалгаа, түүнчлэн яам, агентлаг, төрийн болон бусад байгууллагын хүсэлтээр 200 гаруй удаагийн мэдээллийн боловсруулалт хийж хэрэглэгчдийг мэдээллээр ханган ажиллалаа. Тухайлбал:  <i>*Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд:</i>          -Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэгт шаардлагатай мэдээллийг <b>3 удаа;</b>          -Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтооход шаардлагатай мэдээллийг <b>2 удаа, 12 хувилбараар;</b>          -Засгийн газрын 2023 оны 238 дугаар тогтоолын дагуу хийгдсэн тэтгэврийн нэмэгдлийн талаар иргэдээс гаргасан хүсэлтийг судлах зорилгоор:          -2013 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх тэтгэвэр тогтооход баримтлах сарын хөдөлмөрийн хөлсний дээд</p>	
--	--	--	---	---	--	--

				<p>хангасан байна.</p> <p>4. Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан төрийн байгууллагат ай мэдээлэл солилцох үйлчилгээг өргөжүүлж, тогтвортой ажиллагааг хангасан байна.</p>	<p>хэмжээ 1,404.0 мянган, 1,503.8 мянган, 1,600.0 мянган, 1,700.0 мянган, 1,800.0 мянган, 1,920.0 мянган төгрөгөөр өөрчлөх тооцооллыг;</p> <p>-2023 оны 06, 07, 08 сарын байдлаарх нийт тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө, дундаж тэтгэврийн хэмжээг;</p> <p><i>* Улсын их хурлын Хянан шалгах хороонд:</i></p> <p>- Зарим ажил олгогчийн 2010-2023 оны хооронд ажилласан ажилтнуудын дэлгэрэнгүй мэдээллийг үндсэн ажил мэргэжлийн кодоор;</p> <p><i>*Үндэсний статистикийн хороонд:</i></p> <p>- ҮСХ-ны даргын 2013 оны 1/158 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2022 оны 4-р улирал, 2022 оны бүтэн жил, 2023 оны 1, 2, 3 дугаар улирлын байдлаарх ААНБ-ын ажилтны тоо, цалин хөлстэй холбоотой <b>34 хүснэгтэн мэдээллийг 5 удаа;</b></p> <p>- ҮСХ-ны даргын 2018 оны А/137 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2022 он болон 2023 оны эхний хагас жилийн нийгмийн даатгалын салбарын <b>23 хүснэгтэн мэдээллийг 2 удаа;</b></p> <p><i>* Сангийн яаманд:</i></p> <p>- 2022 оны 01 сараас 2023 оны 08 сарыг дуустал хугацааны ажил болон албан журмын даатгуулагчийн ажил мэргэжлийн ангилал, ажилласан жил, даатгуулагчийн төрөл, нас хүйс, цалингийн сан, шимтгэлийн дүн</p>
--	--	--	--	--	--

					<p>зэрэг томоохон мэдээллийг;  <i>*Эдийн засгийн хөгжлийн яаманд:</i>  - Гадаадын хөрөнгө оруулалттай нийт 11.0 мянга гаруй ААНБ-ын 2018-2023 оны байдлаарх цалингийн сан, ногдуулсан шимтгэлийн дүн, монгол, гадаад даатгуулагчийн тоог;  <i>* Үндэсний аудитын газарт:</i>  - 2022 онд даатгуулсан албан журмын монгол даатгуулагчдын дэлгэрэнгүй мэдээллийг;  <i>*Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт:</i>  -2021-2023 онд нийгмийн даатгалын үйлчилгээ авсан даатгуулагчдын тоон мэдээллийг үйлчилгээний төрөл /тэтгэвэр, ЖА, ажилгүйдлийн, оршуулгын, ХЧТА-ы болон ҮОМШӨ-ий тэтгэмж, СДД, ЭМД/-өөр <b>2 удаа;</b>  <i>* Дэлхийн банкинд:</i>  - Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хуулийн дагуу 2022 оны 5-12 саруудын буцаан олголттой холбоотой 3 төрлийн мэдээллийг 17 үзүүлэлтээр;  <i>* Хөгжлийн банкинд:</i>  -Жагсаалтаар ирүүлсэн 61 ААНБ-ын 2023 оны 1, 2 дугаар улирлын байдлаарх салбарын тоо, төлсөн шимтгэлийн дүн, даатгуулагчийн тоог;  <i>* Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимд:</i>  -ТОП-100 ААНБ шалгаруулахтай холбогдуулан 2022 оны байдлаар</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>хамгийн олон даатгуулагч, хамгийн өндөр шимтгэл төлсөн эхний 500 ажил олгогчийн мэдээллийг;</p> <p><i>*Хүний эрхийн үндэсний комисст:</i></p> <p>-2019-2022 оны байдлаар тэтгэвэр авагчдын мэдээллийг нийт 7 үзүүлэлтээр;</p> <p><i>* Боловсролын зээлийн санд:</i></p> <p>- Жагсаалтаар ирүүлсэн 1405 их, дээд сургууль төгсөгчийн 2022-2023 онд хамгийн сүүлд шимтгэл төлсөн сарын тоо болон ажил олгогчийн төрлийн мэдээллийг;</p> <p><i>* Улсын бүртгэлийн ерөнхий газарт:</i></p> <p>-Нийт 58.6 мянган хуулийн этгээдийг нийгмийн даатгалын мэдээллийн сангаас регистрийн дугаараар нь шүүж даатгуулагчийн тоо, өмчийн хэлбэр, эдийн засгийн үйл ажиллагааны ангилал, өрийн хэмжээ зэрэг мэдээллийг;</p> <p><i>*Жижиг дунд үйлдвэрийн газарт:</i></p> <p>-Жагсаалтаар ирүүлсэн 1213 ААНБ болон иргэнээс нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн санд бүртгэлтэй байгууллага, иргэний 2012, 2014, 2015, 2022 оны даатгуулагчдын тоо, шимтгэл төлөлтийн мэдээллийг;</p> <p><i>* Эрдэнэс таван толгой ХК-д:</i></p> <p>-Жагсаалтаар ирүүлсэн авто тээврийн 379 ААНБ-ын даатгуулагчийн тоо, ажил мэргэжлийн кодын мэдээллийг;</p> <p><i>* Авлигатай тэмцэх газарт:</i></p> <p>-Зарим ААНБ-ын шимтгэл төлөлтийн мэдээллийг <b>18 удаа;</b></p>
--	--	--	--	--	---

					<p>* ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн алба, Мөрдөн шалгах алба, Экологийн цагдаагийн алба зэрэг байгууллагуудад: - Нэр бүхий ААНБ-ын шимтгэл төлөлтийн мэдээллийг нийтдээ <b>69 удаа</b>;</p> <p>- Шүүхийн байгууллагад:</p> <p>- Нэр бүхий ААНБ-ын шимтгэл төлөлтийн мэдээллийг <b>7 удаа</b> гэх мэт.</p> <p><b>3. Иргэд, даатгуулагч, ажил олгогчдод 4 сувгаар мэдээллийг цахимаар тогтмол хүргэв.</b></p> <p>Төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн “ХУР” системээр дамжуулан иргэд даатгуулагч, ажил олгогчид цахимаар 24/7 цагийн горимоор нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүллээ. Тухайлбал:</p> <p>-<b>"Нийгмийн даатгал" аппликейшнийг</b> нийтдээ <b>270.0 мянга</b> орчим иргэн идэвхтэй ашиглаж 22 төрлийн үйлчилгээ, мэдээллийг цахимаар авсан байна.</p> <p>- <b>“Даатгуулагчид зориулсан вэб”</b> системд <b>1.6 сая</b> орчим удаагийн хандалт хийж 29 төрлийн үйлчилгээг цахимаар авсан байна.</p> <p>- Нийт <b>30.0 мянга</b> даатгуулагч сайн дураар даатгуулах гэрээ байгуулах, хугацаа сунгах, төлбөрөө төлөх үйлчилгээнд онлайнаар хамрагдсан байна.</p> <p>- Давхардсан тоогоор <b>93.5 мянган</b> ажил олгогч, <b>2.1 сая</b> даатгуулагч цахимаар хандан QR</p>
--	--	--	--	--	--

					<p>кодтой шимтгэл төлөлтийн тодорхойлолтоо авсан байна.</p> <p>- Төрийн үйлчилгээний <b>109 ТҮЦ машинаас 114.7 мянган</b> даатгуулагч, ажил олгогч дөрвөн төрлийн лавлагаа, тодорхойлолтоо хэвлэн авсан байна.</p> <p>- НДШ төлөлтийн лавлагаа тодорхойлолтын бодит байдлыг шалгах вэб системээр Элчин сайдын яамдууд, банк, санхүүгийн байгууллагаас <b>4.5 мянган</b> ажил олгогч, <b>34.5 мянган</b> даатгуулагчийн шимтгэл төлөлтийн QR кодтой тодорхойлолтыг шалгасан байна.</p> <p>- Идэвхтэй шимтгэл төлж буй <b>56.8 мянган</b> ажил олгогч сар бүрийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангаа 100% цахимаар, үүнээс 23% нь тоон гарын үсгээр баталгаажуулан илгээсэн байна.</p> <p>- “Шимтгэлийн цахим систем”-ээр <b>3.8 мянган</b> ажил олгогчийн <b>48.7 мянган</b> тушаалын мэдээллийг цахимаар хүлээн авсан байна.</p> <p>- Нийт <b>1218</b> эрүүл мэндийн байгууллагаас <b>174.9 мянган</b> даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны, <b>64.3 мянган</b> даатгуулагч жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн, нийт <b>239.2 мянган</b> эмнэлгийн хуудас цахимаар хүлээн авсан байна.</p> <p>- “Шимтгэлийн цахим систем”-ээр <b>16.7 мянган</b> ажил олгогч <b>144.0 мянган</b> даатгуулагчийн ХЧТА-ны тэтгэмжийн тооцооллыг хийж цахимаар илгээсэн байна.</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>- Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болсон <b>1.6 мянган</b> даатгуулагч ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авах хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад цахимаар илгээсэн байна.</p> <p>- Төрийн цахим үйлчилгээний <b>E-MONGOLIA</b> нэгдсэн порталаар 12 төрлийн лавлагаа тодорхойлолт үзүүлж байгаа бөгөөд үүнээс 5 лавлагаа тодорхойлолт нь англи хэлээр гарч байна.</p> <p>- Түүнчлэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй өгөгдлийн жагсаалт", Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолоор баталсан "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам"-ын дагуу 2022 оны 4, 2023 оны 1, 2, 3 дугаар улирлын 16 нэр төрлийн нээлттэй мэдээллийг тус бүр дөрвөн форматаар хувирган ЗГХЭГ-ын <a href="http://www.opendata.gov.mn">www.opendata.gov.mn</a> болон НДЕГ-ын <a href="http://www.ndaatgal.mn">www.ndaatgal.mn</a> веб сайтуудад цаг тухай бүрд нь байршуулсан.</p> <p><b>Г. Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр мэдээлэл солилцох ажлыг өргөжүүлэн хэвийн ажиллагааг ханган ажиллав.</b></p> <p>Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг өргөжүүлэх ажлын</p>
--	--	--	--	--	--



					<p>хүрээнд шинээр <b>7 сервис</b> боловсруулан ХУР систем болон E Mongolia порталаар дамжуулан хэрэглэгчийг ашиглах боломжийг бүрдүүлсэн.</p> <p><b>ХУР системд:</b></p> <ol style="list-style-type: none"><li>1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас “Өрхийн нэгдсэн мэдээллийн сан” үүсгэхтэй холбогдуулан даатгуулагчийн цалин, тэтгэврийн мэдээллийн сервис;</li><li>2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн санг үүсгэхтэй холбогдуулан аж ахуйн нэгж, байгууллагын даатгуулагчдын тоо болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоон мэдээллийн сервис;</li><li>3. Малчид тариаланчдад төрөөс олгох урамшуулалд зориулсан сайн дурын даатгалын гэрээний мэдээллийн сервис.</li></ol> <p><b>E-Mongolia портал /И-Монгол академи УТҮГ/-д:</b></p> <ol style="list-style-type: none"><li>1. Иргэд даатгуулагч хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актын батлагдсан маягтаар 22 төрлийн мэдээлэл агуулсан сервис;</li><li>2. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоосон актыг англи хэлээр авах сервис;</li><li>3. ЭХМК-ын хурлаар тогтоолт, сунгалт хийлгэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэхний мэдээлэл дамжуулах сервис;</li></ol>	
--	--	--	--	--	---	--

						<p>4. 2019-2023 онд дараалсан 6, 7 жилийн цалин хөлсний дунджаас тэтгэврээ тогтоолгосон тэтгэврээр авагч тэтгэврээ нэг удаа өөрчлөн тогтоолгох хүсэлтээ цахимаар илгээх сервис.</p> <p>Мөн төрийн мэдээлэл солилцооны ХУР систем шинэчлэгдсэнтэй холбогдуулан уг шинэчилсэн хувилбараас иргэний бүртгэлийн мэдээллийг авч ашиглах боломжийг бүрдүүлэн ажиллалаа.</p>	
<b>Нийт үнэлгээ</b>							<b>96.52</b>

*Төлөвлөгөөг хянасан:*

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД

.....

***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

Х.БУЛГАНТУЯА

*Төлөвлөгөөг тайлагнасан:*

НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

.....

***Төсвийн шууд захирагч***

Л.МӨНХЗУЛ

